

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

INVEST MONGOLIA-2017

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД
“ДОЛОО БУУДУУЛСАН ЧОНО”
ШИГ ХАШИРЛАЖ БАЙНА

НИЙТИЙН ЭЗЭМШИЛИЙН ТАЛБАЙ
ХЭСЭГ БҮЛГИЙН ЭЗЭМШИЛ
БИШ БАЙЛТАЙ

Өгөр +22
Шөнө +4

IV нүүрт

VII нүүрт

Дугаарын 60 мөр

Шүлхий л биш шүү,
Су дарга аа

Б.ЭРХЭС

Хүн амынхаа тооноос хэдэн зуу дахин их малтай монголчууд малаа эдийн засгийн эргэлтэд оруулах тухай их л олон жил мөрөөдлөө. Харамсалтай нь малын тоо толгой 60 саяд хүрчихсэн атлаа махаа үнэд оруулах хүсэл маань мөрөөдөл хэвээр өнөөдрийг хүрч байна. Салбар яам энэ талаар тун их анхаарч буй. Тэдний ажлыг муулах гэсэн хэрэг огт биш. Хууль эрхзүйн орчноо баталж, малаа эрүүлжүүлэх талаар ч чамгүй ажил хийж байгаа. Гэвч сайны хажуугаар саар гэгчээр төрийн бодлогыг үл тоодог, амин хувна хичээсэн хүмүүс хаа сайгүй олширчээ. Өвчтэй гэж устгалд оруулахыг үүрэгдсэн малаа нядалчихаад хот руу зөөхөөр санаархаж байсан тохиолдол гарч байсныг ч нуух аргагүй.

Үргэлжлэл нь III нүүрт

ДЭН БУУДЛУУД ГЭМТ ХЭРГИЙН ҮҮР УУРХАЙ БОЛЖЭЭ



Г.УЯНГА

Дэн буудлууд гэмт хэргийн үүр уурхай

болоод байхдаа яахав дээ, хэтэрхий суржигнэлээ гэж зарим нь хэлэх биз. Тэгвэл эхлээд хэдхэн жишээ татъя. Хамгийн сүүлд

гэхэд “Очир” төвийн зочид буудалд 13 настай охин амиа алдлаа.

Үргэлжлэл нь III нүүрт

АЙЛЧЛАЛ

ӨНДӨР ХҮЛЭЭЛТТЭЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЙЛЧЛАЛ

Б.ТОГТОХ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дорнын эдийн засгийн форумд оролцохоор ОХУ-ын Владивосток хотод өчигдөр газардлаа. Ерөнхийлөгч Х.Баттулгыг ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины бие төлөөлөгч И.Е.Левитин, Гадаад хэргийн дэд сайд В.В.Моргулов, ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизов, Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Дэлгэрмаа нарын зэрэг албаны хүмүүс Владивостокийн нисэх онгоцны буудалд угтан авсан юм.

Дорнын эдийн засгийн форум нь ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины санаачилгаар гурав дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд энэ удаагийн форумд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНСУ-ын Ерөнхийлөгч Мун Жэ Ин, Японы Ерөнхий сайд Шинзо Абэ нарын зэрэг төр, засгийн тэргүүнүүд оролдож байгаа юм.

Үргэлжлэл нь II нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

МАН-ын 60 тэрбумын хэргийг хаажээ

Б.ӨНӨР

Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурорын орлогч Ж.Ариунаа өчигдөр олны анхааралд орсон тус газрын хяналтад байгаа зарим хэргүүдийн талаар мэдээлэл өглөө. Тодруулбал, МАН-ын удирдлагын бүтцийн зарим гишүүдийн нэр холбогдсон 60 тэрбумын хэрэг, УИХ-ын гишүүн Д.Гантулга хүчингийн хэрэг үйлдсэн эсэх, Сайншанд үйлдвэрийн асуудлаар тайлбар өгчээ. Д.Гантулга гишүүний хэрэг нэмэлт мөрдөн байцаалтад байгаа учраас дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөс татгалзсан бол МАН-ын гишүүдийн ярилцсан төрийн албан тушаалыг 60 тэрбумаар

наймаалцсан гэх бичлэгийг шалгаж үзээд хэрэг үүсгэх үндэслэлгүй хэмээн хаажээ. Тодруулбал, тус газрын зүгээс АТГ, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажлын хэсэг байгуулж улмаар бүх шатанд ажиллаж буй 3000 гаруй төрийн албан хаагчдыг шалгаж, нэр бүхий хүмүүсийн дансны хөдөлгөөнийг ч хянажээ. Мөн төрийн албыг хууль бусаар авахын тулд сонгуулийн дүнд нөлөөлсөн эсэхийг ч шалгаж ямар нэг зөрчилтэй асуудал илрээгүй учраас МАН-ын дарга М.Энхболд, Нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуй болон түүний зөвлөх А.Ганбаатар нарт хэрэг үүсгэхээс татгалзжээ. Түүнчлэн, иргэн Г.Доржзодовын задалсан 60

тэрбумын хэрэгт холбоотой бичлэг, зураг баримтуудыг ч нэгбүрчлэн шалгасан байна. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн дүгнэлтүүдийг үндэслэн энэхүү бичлэг нь эх хувиараа биш, гурван хүний дуу дүрсний бичлэгийг эвлүүлэг хийж дүрс, текст оруулж монтаж хийсэн гэсэн дүгнэлтэд хүрсэн аж. Өөрөөр хэлбэл, Шүүхийн шинжилгээний тухай хуульд шинжилгээний объект нь заавал эх хувь байна гэдэг заалттай гэнэ. Энэ утгаараа дээрх бичлэгүүд нь эх хувь биш хуулбар байсан тул шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй байдлыг бий болгосон хэмээгээд хэргийг хаажээ.

АЖИЛД АВНА

Гэрэл зурагчин
/зургийн аппараттай бол давуу тал болно/
ЭХ БЭЛТГЭГЧ
/Indesign, Photoshop/
СЭТГҮҮЛЧ
/2017 онд их, дээд сургууль төгссөн байж болно/
Утас: 99189158

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Манай сонины
IV улирлын
захиаага
үргэлжилж
байна

Улиралд 64 дугаар

Захиаагын үнэ
22400

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2428.00	2444.00	ФУНТ	3078.00
ЕВРО	2841.00	2909.00	РУБЛЬ	39.80
ИЕН	21.95	22.53	ЮАНЬ	364.00

ҮЗЭЛ БОДОЛ

ДЭН БУУДЛУУД ГЭМТ ХЭРГИЙН ҮҮР УУРХАЙ БОЛЖЭЭ

Дугаарын **60** мөр
Шүлхий л биш шүү, Су дарга аа



Үргэлжлэл.
Түүрүү нь I нүүрт

Түүнтэй хамт 20 гаруй насны гурван залуу байсан талаар мэдээлэл ч цацагдаад байна. Ямартай ч энэ хэргийн буруутныг эрэн сурвалжилж, хэрэгт холбоотой гэх залуусыг шалгаж эхэлсэн чихэнд чимэгтэй мэдээлэл дуулдлаа. Зарим хэвлэлүүд охиныг эдгээр залуус харахын аргагүй болтол хэрцгийгээр зодож хөөсөн хэмээн мэдээлж байгаа билээ. Харин цагдаагийн байгууллагын анх өгсөн мэдээллээр бол ил харагдах шарх сорвигүй байсан гэдэг. Мэдээллийн зөрүүтэй байдал чухал биш. Хамгийн гол нь 13-хан настай охиныг зочид буудалд яагаад оруулав гэдэг л өнөөдрийн нийтлэлийн гол нөхцөл болоод байгаа юм. Ийм хэрэг маш олон гарсан. Бүр он сартай нь бичсэн ч болно. Өнгөрсөн жил гэхэд л 32 настай эмэгтэй зочид буудалд нас барсан. Бас л хоёр гурван залуутай хамт архи ууж байхдаа зодуулж, улмаар нас барсан байдаг. 2015 онд их сургуулийн хоёр оюутан зочид буудалд өөрсдийгөө боомилж нас барсан хэрэг гарч байлаа. Нялх үрээ хүртэл зочид буудлын өрөөнд хаяж байсан жигшүүртэй хэргийг бид одоо ч мартаагүй. Зочид буудалд мансуурч байгаад баригдсан, гэвэл биеэ үнэлж байсан хэргүүдийг жишээ татвал цаг ч хүрэхгүй цаас ч багадна. Энэ мэтээр он сартай, өдөр судартай нь бичээд байвал дэн буудлуудад гарсан хэрэг бүтэн ном болохоор их байгаа юм. 2015 онд нийслэлийн хэмжээнд зочид буудалд 192 гэмт хэрэг гарч байсан тоон баримт бий. Харин 2016 онд зочид буудалд гарсан гэмт хэргийн тоо 220 гаруй байгаа нь эдгээр дэн буудлуудад тавих хяналт, хариуцлага жилээс жилд байхгүй болж буйг бэлхнээ харууллаа. Ийм байхад гэмт хэргийн үүр уурхай гэж хэлэхгүй яах билээ. Гэхдээ зочид буудал гэхээр бүгдийг нь хамаатуулж болохгүй гэдгийг уншигч авхай ч ойлгох биз. Өндөр зэрэглэлтэй, одтой, ном дүрмийнхээ дагуу үйлчилгээ явуулж байгаа зочид буудалд хэрэг төвөг гарна гэж байхгүй юм. Харин зочид буудал нэртэй хоног төөрүүлэх дэн буудлуудад янз бүрийн хэрэг төвөг гарч, хууль бус үйлдлийн үүр уурхай болчихоод байгааг хөндөхгүй өнгөрч боломгүй нь. Ядахад зөвшөөрөлгүй зочид буудал Улаанбаатар хотод маш олон байдаг гэдгийг цагдаагийн байгууллагын шөнийн эргүүл, гэнэтийн шалгалт зэргээс харж болохоор. Нийслэлд өнөөдрийн байдлаар зөвшөөрөлгүй, эс бөгөөс стандарт хангаагүй

хэчнээн буудал үйл ажиллагаа явуулдаг вэ гэдгийг нарийвчлан гаргасан тоон баримт алга. Хамгийн сүүлд буюу 2014 оны арваннэгдүгээр сард нийслэлийн аялал жуулчлалын газраас шалгалт явуулж тоон мэдээг нэгтгэн гаргаж байжээ. Энэ шалгалтын явцад 102 зочид буудал зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан гэсэн мэдээлэл өгсөн байна. Тухайн үедээ зөвшөөрөлгүй зочид буудлуудыг цахилгаан, ус, дулаанаар хангахгүй байх шийдвэрийг нийслэлээс гаргаж байсан ч ажил хэрэг болсон эсэх талаар мэдээлэл огтхон ч алга. Ер нь бол Улаанбаатар үйл ажиллагаа явуулж байгаа элдэв зочид буудлын тоо жилээс жилд нэмэгдэж, тэр хэрээр зочид буудалд гарах гэмт хэргийн тоо өссөөр байгааг хэдхэн буруудахгүй. Монголд ирж байгаа гагцны жуулчид гэр хороолол дунд, эсвэл хотын зах хавиар байгаа сампирсан дэн буудалд буухгүй нь тодорхой. Хөдөөнөөс ирсэн хүмүүс ч буудалд байрлах гэхээсээ илүү хамаатан садан, танил талаа бараадаж хэд хоноод л буцдаг. Хаа нэгхэн сургууль, цэцэрлэгийн багш нар сургалтад суух гэж ирдэг ч гэр хорооллын дэн буудалд хоног төөрүүлжээ доройтно гэж байхгүй биз. Тийм байхад яагаад байшин болгон зочид буудал болоод байна вэ. Үүнд нэг л хариулт байгаа. Дундаж зэрэглэлээс эхлээд дэн буудал бүрт биеэ үнэлэлт цэцэглэж байгаа нь худлаа биш. Бүр тун гайгүй зэрэглэлтэй болов уу гэсэн зочид буудлын хонгилын давхарт гулгаа массажны газар байдгийг цагдаагийн албан хаагчид илрүүлсэн гэх мэдээлэл олонтой дуулддаг. Массажист охидууд нь биеэ үнэлээд л. Дээрээс нь гудамжинд биеэ үнэлж байгаа эмэгтэйчүүдийн үйлчилгээг дагуулаад очдог газар нь буудал нэртэй сампирсан газрууд шүү дээ. Бүр биеэ үнэлэгчидтэй тохирч үйлчилгээ үзүүлдэг тухай ч ам дамжсан яриа байдгийг нуух юун. Дээрээс нь архиндаа халамцсан, үргэлжлүүлж уух хүсэлтэй залуучуудын хоног төөрүүлдэг, согтуурдаг газар нь бас эдгээр дэн буудлууд. Хар тамхи татдаг, цавуу, газ үнэрлэж мансуурдаг залуучуудын орогнодог газар нь ч бас л дэн буудал. Ердөө л ийм хүмүүсээс хэдэн төгрөг авах зорилготой л зочид буудал байгуулж байгааг хэн ч үгүйсгэж чадахгүй. Хотын захын зарим буудлууд талыг нь хаачихсан байхад нийслэл буудлаар лав дутагдаж, гачигдахгүй. Харин зочид буудалд гарч байгаа гэмт хэргийн тоо л буурах байх.

охид амна алддаг боллоо. Хэдий болтол тэднийг даврах билээ, дарга нар аа. Ердөө гуравхан сая хүн амтай нийслэл хотдоо сая гаруйхан иргэнтэй манайд 400, 500 зочид буудлын хэрэг байдаг гэж үү. Хатуухан хэлэхэд, архидалт, биеэ үнэлэлтийг дэмжээд байгаа юм биш үү. Гэмт хэрэг, биеэ үнэлэлтийн үүр уурхай болсон дэн буудлуудыг хаах хэрэгтэй байна. 2014 онд зөвшөөрөлгүй 100 гаруй буудал байсан тухай дээр дурьдсан. Одоо энэ тоо хэд ч хүрч байгаа юм билээ. Ядаж л зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулаад байгаа буудлуудаа хаалгыг нь бариад авахад 100 гаруйгаар тоо нь буураад л явчихна гэсэн үг. Уг нь бол буудал нээх гэж байгаа хүнээс зэрэглэл шаардах хэрэгтэй. Ядаж л нэг одтой буудал байвал хамаа замбараагүй архидалт согтуурсан бүхнийг хяналтгүйгээр оруулахгүй шүү дээ. Монгол Улсын хууль тогтоомжийг бага ч гэсэн мөрддөг байсан бол насанд хүрээгүй жаахан охин зочид буудлынх нь өрөөнд зодуулж байгааг мэдэх л ёстой баймаар. Үгүй ядахдаа бичиг баримтыг нь шалгаж оруулахгүй харамтэй хориг тавьж, энэ талаар мэдээллийг цагдаад өгчихсөн бол өнөөдөр нэг айл өнчирч, цэцэг цэврүү шиг охин бусдын гэрт амиа алдахгүй байлаа. Дэн буудлууд мөнгөө л авч байвал хэн ч байсан оруулдаг гэдгийг энэ хэрэг тод томруунаар харуулчихлаа. Өнгөрсөн жилүүдэд насанд хүрээгүй хүүхэд зочид буудалд амиа алдсан, гэмт хэрэгт холбогдсон, мансуурсан хэрэг өч төчнөөн гарсан. 14-хөн настай охиныг зочид буудалд байлгаж, хүчээр биенийг нь үнэлүүлж байсан хэрэг ч гарч байлаа. Энэ бол зочид буудлууд бүртгэл хөтөлдөггүй, иргэний бичиг баримтыг шалгалтадгүй гэдгийг баталсан том баримт шүү. Нийслэлийн аялал жуулчлалын газраас 2014 онд явуулсан шалгалтаас хойш нэгдсэн шалгалт ер нь хийгдсэн үү. Хийсэн бол түүнийг олон нийтэд мэдээлж, сэрэмжүүлээч. Бүр нэр устай нь зарласан ч яадаг юм. Бүртгэл хөтөлж байна уу, зочид буудлуудад массажны газар байгаа эсэх гээд шалгах зүйл өч төчнөөн байгаа шүү дээ. Энэ мэтээр төрийн байгууллагууд хяналт, шалгалтаа эрчимжүүлж, хаах шаардлагатайг нь хааж, хатуу гараар тэмцээр байна. Улаанбаатар хотод байгаа зочид болоод дэн буудлуудын талыг нь хаачихсан байхад нийслэл буудлаар лав дутагдаж, гачигдахгүй. Харин зочид буудалд гарч байгаа гэмт хэргийн тоо л буурах байх.

Үргэлжлэл.
Түүрүү нь I нүүрт

Энэ мэтээр малчид хүртэл хүн чанараа алдаж зөвхөн мөнгөний хойноос хөөцөлдөх болсон цөвүүн цаг ирээд байна. Малынхаа чанарт бус тоонд хэт анхаарч, олон малтай гэсэн жижигхэн нэр хүндээ болж монгол малын чанар улам бүр муудсаар байгааг худлаа гэж хэлэхгүй биз ээ. Хаа хаанаа чин сэтгэл дутаж байгаа учраас бид олон жилийн мөрөөдөө ажил хэрэг болгож чадахгүй өнөөдрийг хүрлээ. Монгол малын мах чанартай ч өвчтэй гэсэн сөрөг пиар дэлхий дахинд байдаг учраас талын монголын таана амтагдсан амттай махыг бус угааж, ариутгасан амт чанаргүй махыг дэлхий дахин сонирхож байгааг буруутгах аргагүй юм. Хамгийн гол нь тэдэнд аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага чухал учраас ийм сонголт хийж буй. Тэгвэл шүлхий өвчний голомт нийслэлд илэрсэн аймшигтай мэдээ дуулдах болов. Харамсалтай нь үүнийг тоож байгаа хүн алга. Нэг сая гаруй хүн амтай мега хотод малын өвчлөл гарна гэдэг нь өөрөө асар өндөр эрсдэл дагуулж байгаа бус уу. Устгах үүрэг өгсөн малыг зарах гээд зогсч байсан хүмүүс санаатай болон санамсаргүй байдлаар шүлхий өвчлөлтэй махыг хүнсэнд нийлүүлвэл хэрхэж билээ. Нийслэлийн орц хонгил бүрт байрлах байгаа цайны газар, ресторанд өвчтэй малын мах очихгүй гэсэн баталгааг хэн ч өгч чадахгүй. Хэдийгээр тархалтыг хянаж, хорно цээрийн дэглэм тогтоосон ч бидний хаяанд ирчихээд байхад эрсдэлгүй ээ гэж хэлэх эрүүл ухаантай хүн байхгүй гэж найдъя. Цаашлаад хүнд халдвал шигүү суурьшилтай хот тосгонд ямар аюул дагуулахыг эрхэм хотын удирдлагууд мэдээгүй сууна гэж үгүй л байлтай. Хотын удирдлага зөвхөн энэ асуудлаас болж огцрох учиртайсан. Гэтэл манай дарга нарт хүн амынх нь аюулгүй байдлаас илүү ТҮЦ-ний худалдаа чухал бололтой. Ширхэгийн тамхи, бохь зарж амьдралаа дагуулж буй ядарсан ард түмэндээ л ид шидээ үзүүлэхээс бус нийслэлийн иргэд нь хордох эсэх нь туй ч хамаагүй байгаа зөвтгөх ухаан олдохгүй нь. Баруун, зүүн тийшээ эргэх эсэхэд л цаг зарцуулахаас бус шүлхийн өвчлөл нийслэл хотод нь аюул дагуулж буйг анхаарах сөхөө алга, манай дарга нарт. Улаанбаатар хот сүүлийн жилүүдэд аюулгүй, эрүүл хот болохын тулд хичээж буй. Тэр ч байтугай жуулчдад хамгийн ээлтэй хот байх зорилго тавьж, шөнийн гудамж хүртэл нээсэн. Энэ бүхэн зөвхөн аялал жуулчлалын сэргээхэд чиглэсэн арга хэмжээ. Жилдээ хэдэн арван тэрбумаар олон янзын баяр наадам хийж жуулчдын сэтгэлийг татахаар хичээдэг болсон. Гэтэл энэ бүх хичээл зүтгэлийг зөвхөн шүлхий хотод ороод ирчихэж гэсэн гуравхан үг үгүй болгоно гэдгийг сануулахад илүүдэхгүй биз. Су.Батболд дарга аа. Шүлхийд тавих хяналтаа сайжруулаач. Нийслэлийн хэмжээнд онцгой байдал зарласан ч яах вэ. Ширхэгийн бохь, тамхины худалдаачдад бүр болохгүй бол нийслэлд малтай айл өрх байлгахгүй гэж захираамж гаргасан ч яадаг юм. Нийслэлд худалдаалагдаж буй мах, махан бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах талаар холбогдох газар хэлтэстэйгээ ойрхон ажиллаач. Салбар яамтай хамтраад ч болов өвчтэй малаас хурдхан ангижрах талаар ажиллаж болохгүй юу. Эс бөгөөс та хариуцлагаа хүлээ. Зүүн эргэлт гэх мэт жижиг асуудлаас илүү нийслэлийн иргэдийн эрүүл хүнс эсрэгтэй нэг тэргүүний хүслийг хангах талаар ажиллаач гэж энэ талаар ажилладаг бүх газрын дарга, удирдлагаас хүсэж байна. Нийслэлд асуудал мундахгүй их байна. Шүлхий л биш шүү.

ХЭВЛЭЛИЙН ХУРАЛ

Монгол иргэн өмнөд хөршид хилсээр ял эдлээгүй гэв

Б.ЭРХЭС

Гадаад харилцааны яамны Консулын газраас өчигдөр сүүлийн үед нийгмийн анхаарал татаж буй сэдвээр мэдээлэл хийлээ. Тодруулбал, БНХАУ-д хилс хэрэгээр ял эдэлж, хоригдох хутагтаандаа 60 хоног өлсгөлөн зарласан хэмээх иргэн Б-ийн талаар ташаа мэдээлэл гарч байгаа учраас залуулга хийсэн юм. Тэрбээр, “Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн цахим сүлжээгээр БНХАУ-д ял эдэлж байгаад эх орондоо буцаж ирсэн Монгол Улсын иргэн н.Батгэрэл болон түүний ар гэрийнхэн буруу ташаа мэдээлэл түүгээр энэ нь хоёр улсын харилцаанд сэв суулгах хэмжээнд хүрлээ. Өмнөд хөршийн хууль хяналтын байгууллагын талаар буруу ойлголт өгч байгаа. Консулын газар, Гадаад харилцааны яам н.Батгэрэлтэй холбоотой асуудалд өндөр анхаарал хандуулсан. Энэ иргэн хулгайн

хэрэгт холбогдсон. Хэрэгт шалгуулах явцад хүндээр өвдсөн учраас бид ар гэрийнхэнтэй нь холбогдож, Эрэн дахь консулын шугамаар дамжуулан эх оронд нь хүмүүнлэгийн шугамаар авчрах асуудлыг удаа дараа тавьж байсан. Ц.Мөнх-Оргил сайд өөрөө биечлэн энэ асуудалд анхаарал хандуулж байсан юм. Хэргийг нь хэрэгсэхгүй болгож өгөөч ээ гэсэн сайдын хүсэлтийг Хятадын тал анхаарч наймдугаар сарын дундуур шүүхээс иргэн н.Батгэрэлтэй холбоотой хэргийг хэрэгсэхгүй болгосон. Гэтэл түүний хуурай дүү гэгдэх нэгэн иргэн Хятадын шоронд хилсээр хоригдсон, өлсгөлөн зарласан гэх мэтээр ташаа мэдээлэл гаргасанд харамсч байна. Ар гэрийнхэн нь өөрсдөө иргэнээ эх оронд нь авчирсанд баярлалаа гэж бидэнд хэлсэн байгаа. Тэд удахгүй залуулга хийхээ мэдэгдсэн” гэв. Түүнчлэн, Замын-Үүдээс Эрэн гарч буй автомашины шалгалттай



холбоотой асуудлаар мэдээлэл өгөв. Эрэн хотын Ардын засгийн ордоноос энэ сарын 15-ны өдрөөс эхлэн Замын-Үүдээс Эрэн хот руу гарч байгаа манай улсын иргэдийн автомашинд шалгалт хийх ажлаа эрчимжүүлнэ хэмээжээ. Өөрөөр хэлбэл, манай улсын иргэд өнгө үзэмж муутай, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаагүй, согтуугаар

тээврийн хэрэгсэл жолоодох гэх мэтээр зөрчил их гаргадаг аж. Манай улсын иргэдтэй холбоотой гомдол санал энэ оны эхний долоон сарын байдлаар 30 гаруй мянга бүртгэгдсэн гэдгийг албаныхан онцолсон юм. Тиймээс хяналт шалгалтаа эрчимжүүлсэн аж. Монгол Улсын жолооч нарт хятад улсын иргэдтэй адилхан зөрчил ногдуулж, онооны

системээр асуудлыг шийдэн, мөнгөн торгууль ногдуулахаар болсон гэв. Мөн Хятад улсад суралцахаар явж буй оюутан залуус БНХАУ-ын Элчин сайдын яамны гадаа урт очер үүсгэж байна гэсэн иргэдийн мэдээллийн дагуу Элчин сайдын яамтай уулзаж ахиц дэвшил гаргажээ. Өөрөөр хэлбэл, нэг өдөрт 60 визний мэдүүлэг авч байсныг 100 болгож, мөн долоо хоногийн ажлын дөрвөн өдөр визний хүсэлт авах талаар Элчин сайдын яамтай зөвшилцөлд хүрсэн байна. Мэдээллийн төгсгөлд өмнөд хөршийг зорьж буй иргэдэд таатай мэдээлэл дуулгав. Тодруулбал, Эрэн хотод байрлах манай улсын Консулын газар Эрэн хотын Ардын засгийн ордны Хууль-зүйн товчоотой хамтраад иргэд дээг урд хөршийн хууль эрхзүйн орчны талаар үнэгүй зөвлөгөө өгдөг болжээ. Иргэдэд монгол хэлээр ярьдаг, бичдэг өмнөд хөршийн туршлагатай иргэд хуульзүйн зөвлөгөө өгөх гэнэ.

ЭДИЙН ЗАСАГ

"INVEST MONGOLIA-2017"

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД "ДОЛОО БУУДУУЛСАН ЧОНО" ШИГ ХАШИРЛАЖ БАЙНА



Г.ГАНЧИМЭГ

Монгол Улсын Засгийн газар томоохон төслүүдээ удахгүй хөдөлгөж эхэлнэ, дэлхийн зах зээл дээр ээс, нүүрсний үнэ сэргэж байгаа, төсвийн алдагдал буурсан зэргээр бага ч гэсэн эерэг дохионууд эдийн засагт асаад эхэлжээ. Өндөр дүнтэй тоо ярьдаг том эдийн засагтай оронтой харьцуулахад манай улс өөртөө гарч ирсэн багахан боломжийг л зөв ашиглаж чадвал эдийн засаг нь сэргэж, хүн эзэн зоо тэнийж байдгаараа онцлогтой. Магадгүй жижигхэн байхын давуу тал нь энэ байх. Гэхдээ Олон улсын валютын сангийн өргөтгөсөн хөтөлбөртэй тэргүүлэх салбаруудынхаа бодлогыг уялдуулах зайлшгүй шаардлага, өр зээлийн дарамтаа хэрхэн багасгаж, хугацааг нь хойшлуулах вэ гэдэг "шүдний өвчин", улс төрийн тогтворгүй байдал, дэлхийн зах зээл гэж ярьдаг ч үнэндээ түүхий эдийн үнэ нь Хятадын үйлдвэрлэгчдээс ихээхэн хамааралтай эмзэг байдал, зээлжих зэрэглэл нь гуравхан сарын дотор гэрийн хурдаар доошилж буюу хоёр удаа буурсан зэрэг сөрөг зураглалууд ч бас бий. Ийм л хувь тохиол, хур бороо, шавар шалбаагтай намрын өглөө "Инвест Монголиа" олон улсын хөрөнгө оруулагчдын чуулган "Шангри Ла"-д 11 дэх жилдээ нээгдлээ. Хоёр өдрийн турш зохион байгуулагдах энэхүү арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газар болон тэргүүлэх чиглэлийн гол салбаруудын төлөөлөл, санхүүгийн байгууллага, олон улсын хөрөнгө оруулагчид, эдийн засагч мэргэжлэн сэтгүүлчид, Монголын томоохон хэвлэл мэдээллийн төлөөлөл зэрэг 1000 гаруй оролцогч нэг дор цугларсан юм. Тэд бүгдээрээ л улстөржилт, элдэв янзын популизмгүйгээр мэргэжлийн төвшинд нүүр тулан уулзаж, эмх цэгцгүй байгаа буруу ойлголцлоо залруулж, нэгдсэн нэг ойлголттой болох, томоохон төслүүд болоод эдийн засгийн нөхцөл байдал, хууль, эрхзүйн орчин, энэ жилд гарсан томоохон өөрчлөлт, ирэх онд гарч ирэх давуу тал, болзошгүй эрсдэл, банк, санхүүгийн зах зээл, нийгмийн болон хөгжлийн асуудлуудаар үнэнд хамгийн ойр байж болох бодит мэдээллийг анхны албан ёсны эх сурвалжаас нь л авахыг чармайж байлаа. Хэрэв үүнийг бийр будаг ашиглан илэрхийлбэл, Монгол Улс бас ч гэж дампуурлын намаг балчигт арай живчихээгүй байгаа юм байна гэх тайтгарал, аврагдах гарцаа хайж, харцаа эрэг хавьцаа чиглүүлж байгаа горьдлого бүхий дүр зураг л бууна.

Энэхүү чуулганыг Японы хөрөнгө оруулалттай

"Фронтьер Монгол" компани жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. Тус компанийн гүйцэтгэх захирал Маса Игата "Бид сүүлийн гурван сарын турш салбар бүрийн мэргэжилтнүүдтэй ярилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулагчдад тулгамдсан хамгийн чухал асуудлуудыг анхааралтай сонголоо. Чуулга уулзалт маань хэн нэгнээс хараат бус болдог. Хуралд оролцогчдын үзэл бодлыг тэнцвэртэй тусгахыг эрхэмлэдэг юм. Бидний зорилго бол хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалт шаардлагатай ААН-үүд хоорондын ойлголтын зөрөөг арилгаж, хоёр талд стратегийн болон санхүүгийн хувьд харилцан ашигтай байдлыг бий болгох" гэдгийг онцолж байсан.

Ирээдүй цаг дээр ярьдаг хэлбэрээ өөрчлөхийг Ерөнхий сайд шаардав

Харин энэ удаагийн чуулганы нээлтэд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат мэндчилгээ дэвшүүлж, хэлсэн үгэндээ "Сүүлийн 10 гаруй жилд Монгол Улсад шинээр орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь зөвхөн уул уурхай болон түүнтэй шууд хамаарал бүхий салбаруудынх байлаа. Энэ хэрээр манай эдийн засаг олборлох салбараас хэт хамааралтай хэвээрээ байна. Эдийн засгийн өрөөсгөл энэ бүтэц болон бусад хүчин зүйлээс хамааран эдийн засгийн өсөлт тогтвортой бус, хэлбэлзэл ихтэй явж ирсэн гэдгийг та бүхэн сайн мэднэ. Сүүлийн 5-6 жилийн дотор эдийн засгийн өсөлт 17 хувиас нэг хувь болтлоо эрс унасан. Энэ оны эхний хагас жилийн байдлаар эргэн сэргэж, өсөлт 5.3 хувьд хүрлээ. Гадаад худалдааны эргэлт, улсын төсвийн орлогын бүрдэлт, инфляцийн төвшин, мөнгөний бодлого зэрэгт олон эерэг өөрчлөлт гарсан" гэж онцлоод "Хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улс нээлттэй засаглалтай, бизнесийн таатай орчинтой, бизнес хийх зах зээлтэй улс хэвээр байна.

Оюутолгой, Тавантолгой төслийн үйл ажиллагаа эрчимжсэн. Үүнээс гадна ашигт малтмалын шинэ орд газрууд ч илэрч байгаа. Түүхий эдийн үнэ ханш өсч, Оюутолгойн далд уурхайн олборлолт эхлэх болсноор гадаад худалдаа, үүний дотор экспортын урсгал илүү тогтвортой байх урьдчилсан нөхцөл харагдаж байна. Монгол та бүхний сонирхолыг татах бизнес, хөрөнгө оруулах ирээдүйтэй зах зээлтэй улс хэвээрээ байгаа. Харин бизнес эрхлэх, хөрөнгө оруулах орчны тухайд нэг талаас хөрөнгө оруулагчид та бүхэн, нөгөө талаас Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд миний байр суурь ялимгүй зөрөхийг үгүйсгэхгүй. Магадгүй, зарим хөрөнгө оруулагч манай улсын хөрөнгө оруулалтын орчныг "Сайнгүй, эрх зүйн орчин хангалтгүй" гэж болох юм. Үүнтэй би Ерөнхий сайдын хувьд санал нийлэхгүй. Өнөөдөр манай эдийн засгийн

голлох салбарууд, ялангуяа томоохон хөрөнгө оруулалт татдаг уул уурхайн салбар нэлээд жигдэрсэн, хөрөнгө оруулагчдыг хамгаалсан, болзошгүй эрсдлийг зохих төвшинд хаасан, олон улсын жишигт ойртсон эрх зүйн орчинтой болсон. Аливаа хамтын ажиллагаа тал талын эрх ашигт нийцэх эрх зүйн орчинтой байх ёстой. Энэ бол бизнесийн зарчим. Харин ямар ч тохиолдолд хөрөнгө оруулагчдад бус, баялгийн эзэд илүү боломж байх ёстой нь бизнесийн хууль гэдгийг энд сануулахад илүүдэхгүй" хэмээн үзэж буйгаа ч илэрхийлэв. Мөн тэрбээр эцэст нь "Монгол Улсад хөрөнгө оруулах нэг л зорилготой чуулганыг бид янз бүрийн нэршил дор сүүлийн 10 гаруй жил зохион байгуулж ирлээ. Заримдаа жилд хоёр, гурваар нь хийлээ. Цаг зав, хөрөнгө мөнгөө зарцуулаад олон ч хөрөнгө оруулагч ирж байна. Гэвч эдгээр чуулганы бодитой үр дүн амьдрал дээр тэр бүр харагдахгүй, үүнээс болж арга хэмжээ маань өөрөө үнэгүйдэх хандлагатай байгааг зохион байгуулагчид анхаарах хэрэгтэй. Бид цуглаж суугаад ирээдүй цаг дээр олон жил ярилаа. Хөрөнгө оруулалтын ийм чуулганууд одоо хэлбэрийн хувьд дараагийн шатандаа орох хэрэгтэй. Ярьж чуулахаас илүүтэй, хамтарч хийдэг бүтээдэг бодитой хамтын ажиллагаа чухал байна. Энэ удаа үрдүнгүй цугларалт болоод

өндөрлөхгүй гэдэгт итгэж байгаа бөгөөд аль салбарт ямар компани хамтын ажиллагааны эхлэл тавьсан, гэрээ байгуулсан, эргэж уулзахаар болсон гээд чуулганы бодит үр дүнгийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн газарт ирүүлэхийг үүрэг болгож байна. Засгийн газар тэр бүгдийг хуулийн хүрээнд бүх талаар, бодитой дэмжиж хамтран ажиллах болно" гэв.

Хөрөнгө оруулалт 60 хувиар өссөн ч ...

Үүний дараа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат "Хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаална" гэдгээ тус чуулганы индэр дээрээс амласан юм. Гэхдээ энэхүү чуулган, салбар хуралдааны хэлэлцүүлгүүд дээрээс анзаарагдсан нэг зүйл нь ОУВС-ийн өргөтгөсөн хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа, зарим түүхий эдийн үнэ өсч, хамгийн гол түнш болох Хятадын зах зээл улам тодорхой болж байгаа хэдий ч гадаадын хөрөнгө оруулагчдын хандлага мэдэгдэхүйц сайжраагүй гэдэг нь тодорхой болжээ. Тухайлбал, "Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв байдал" хэлэлцүүлгийн үеэр ОУВС-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Нийл Сэкир "Арилжааны банкууд дунджаар

25 хувийн хүүтэй, богино хугацаатай зээл олгож байгаа тул эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхгүй байгаа. Иймд ОУВС банкны системийн эрүүл мэндэд ихээхэн анхаарна" гэдгийг онцлов. Өөрөөр хэлбэл, олон улсын зээлжих зэрэглэл тогтоодог зарим байгууллага манай улсын зээлжих зэрэглэлийг САА1 болгож бууруулснаа нэг хэсэгтээ ангилал байрыг ахиулахгүй нь. Чуулганд оролцсон зарим эдийн засагч үүнтэй санал нийлэхгүй байгаа юм. Улсын төсвийн алдагдал өнгөрсөн сарын байдлаар 500 тэрбум төгрөг болж буурсан, мөн хөрөнгө оруулалтын хууль, эрхзүйн орчин харьцангуй сайжирсан, зарим хөрөнгө оруулагч бодлогод лхэт анхаарч байсан нь сул тал боллоо гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа зэрэг эерэг хандлага, нааштай үзүүлэлтүүдийг авч үзэхгүй байгаад жаахан сэтгэл дундуур үлдлээ. Уг нь Монголд хийж буй хөрөнгө оруулалт 60 хувиар өсчээ. Зөвхөн уул уурхай гэлтгүй эрчим хүч, дэд бүтэц, банк, санхүүгийн зах зээл, хөдөө аж ахуйн салбарыг хөрөнгө оруулагчид сонирхдог болсон байна. Харин тус чуулганы зохион байгуулагч, ноён Маса Игата "Гадаадын хөрөнгө оруулагчдыг эргэлтээ тээгээлээ, хүлээлтэд хүргэдэг зүйл бол Монгол Улсын төр, засгийн тогтворгүй байдал. Монгол Улсын Их хурлаас Засгийн газраа шинэчлэн байгуулах гэж байгаа тухай мэдээлэл олон улсад түгсэн. Засгийн газар нь өөрчлөгдөвөл өмнөх Засгийн газрынхаа хэрэгжүүлж байсан бодлогыг үргэлжлүүлэх эсэх нь тодорхойгүй. Хэрэгжүүлээ гэхэд, яаралтай хийж байсан бодлогын арга хэмжээнүүд удааширах муу талтай. Нөгөөтэйгүүр, шинээр сонгогдсон Ерөнхийлөгч, эрх баригчид өөр өөр намын төлөөлөл байгаагаас зөрчил гарч болзошгүй гэх мэт таамаглалууд нь хөрөнгө оруулагчдыг түгшээж байж магадгүй" гэдгийг үгүйсгэсэнгүй. Юугай ч энэ намжар хөрөнгө оруулагчдын ээлжит чуулган болдог ороо л боллоо. Гэхдээ хөрөнгө оруулагчид "долоон удаа буудуулж шархадсан чоно" шиг хаширлаж байна. Өөрөөр хэлбэл, тэдний Монголд итгэх итгэл бүрэн сэргээгүй аж. Тиймээс өнөөдөр өгч байгаа харилт нь "Магадгүй" эсвэл "Ийм эрсдэлтэй" юм.

САЙН МЭДЭЭ

МОНГОЛ, ОРОСЫН ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТ 34 ХУВИАР ӨСЧЭЭ

С.СЭРГЭЛЭН

Хөршөө сонгож болдоггүй ч, хамтарч ажиллаж болдгийг Ж.Эрдэнэбатын Засгийн газар өнгөрсөн хугацаанд харуулж чаджээ. Саяхныг хүртэл монголчууд нефтийн бүтээгдэхүүн авахаас өөрөөр худалдааны эргэлт нь зогсоод байсан Монгол, Оросын харилцаа өнгөрсөн жил хүрэхгүй хугацаанд хурдацтай өссөн дүн мэдээ байна.

Энэ Засгийн газрын үед хоёр орны харилцаанд мэдэгдэхүйц сэргэлт гарч, худалдааны эргэлт 34 хувиар өсөөд буйг ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгагай уулзах үеэрээ дуулгасан ажээ.

Тодруулбал, Монголын Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Владивосток хотод болох "Дорнын Эдийн засгийн III чуулга" уулзалтад оролцохоор тус улсад айлчилж буй. Энэ нь түүний хамгийн анхны гадаад айлчлал юм. Тэрээр энэхүү чуулга уулзалтын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтай

албан ёсны хэлэлцээр хийнэ. Тэд саяхан Унгарын нийслэл Будапешт хотноо болж өнгөрсөн жүдо бөхийн ДАШТ-ий үеэр анх удаа албан бусаар уулзаж, удахгүй хийх албан ёсны уулзалтынхаа талаар ярилцсан юм. Тухайн уулзалтын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин "Хоёр орны хамтын ажиллагааны талаар Владивостокт илүү дэлгэрэнгүй ярих боломж гарна гэдэгт найдаж байна. Хоёр орны хоорондын худалдааны чиг хандлага сайн байгаа нь нэгэнт тодорхой. Өнгөрсөн онд 20 хувиар унасан худалдаа 2017 оны эхний хагаст 34 хувиар өсөөд байна. Улс төрөөс гадна эдийн засаг, соёлын харилцаа амжилттай хөгжиж байна. Орос, Монголын хамтарсан аж ахуйн нэгж сайн ажиллаж, ачаа тээвэр нэмэгдэж байна. Тиймээс Владивостокт ярих зүйл бидэнд хангалттай их бий" гэсэн юм. Үүнээс үзвэл оны эхний хагаст бий болсон эдийн засгийн өсөлтөд ОХУ-тай хийж байгаа худалдаа багагүй хэмжээгээр нөлөөлж байгаа бололтой.

Эдийн засгийн өсөлт энэ оны эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд

хүрээд байгаа талаар Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат "Invest Mongolia" чуулга уулзалтад оролцохдоо хэлсэн юм. Түүний Засгийн газар байгуулагдаад жил болж гаруй болж байгаа хэдий ч ажлыг нь бүтэн жилээр дүгнэх хугацаа энэ оны эхнээс эхэлсэн. Учир нь, өнгөрсөн оны эхний хагас жилд нь Ч.Сайханбилэгийн Засгийн газар ажиллаж байлаа. Тэгэхээр Ж.Эрдэнэбатын Засгийн газар жинхэнэ бодит дүнгээ тавигдах бүтэн жилийн хугацаа нь хэдхэн сарын дараа дуусна. Ямартай ч эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын бодлого үйл ажиллагаа чамлахааргүй явж байгаа нь дээрх хоёр тооноос харагдаж байна. Тодруулбал, 2016 онд хасах үзүүлэлттэй байсан эдийн засгийн өсөлт энэ оны эхний хагас жилд 5.3 хувиар өсчээ. Мөн ОХУ-тай хийх худалдаа 34 хувиар өссөнийг тус улсын Ерөнхийлөгч В.Путин хэлсэн. Өмнөх жилүүдэд хоёр улсын иргэд хоорондоо визгүй зорчиж байсан ч худалдааны эргэлт ингэж өсөхгүй байсан юм.

ОНЦЛОХ ХУУДАС

АВТО ХУДАЛДААНЫ ЦОГЦОЛБОР РУУ НҮҮЛГЭНЭ, НҮҮХГҮЙ

Эсрэг тэсрэг байр суурь

Ц.Гүрбадам: Шинэ авто цогцолбор нь бүтээн байгуулалтыг улам өргөжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа



/"Авто худалдааны цогцолбор" ОНӨААТҮГ-ын дэд дарга /

-Зам Тээврийн Хөгжлийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан ажлын хэсгийн чиг үүргийн дагуу Нийслэлийн газрын албанаас зорнулалтын бус газарт автомашины худалдаа эрхэлж буй цэгүүдэд үйл ажиллагаагаа хаах мэдэгдэл өгсөн байгаа. Хотын төвийн зургаан дүүрэгт автомашины худалдаа, эрхэлдэг есөн зах, 102 цэгүүд байдаг бөгөөд эдгээр нь газраа зорнулалтын бусаар ашигладаг нэгдсэн зохион байгуулалт байхгүй, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсныг нүүлгэн шилжүүлэхээр болсон. Нөгөөтэйгүүр, Авто Тээврийн Үндэсний төвийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг цогцолборт шилжүүлж, импортын машины бүртгэлийг зөвхөн авто худалдааны цогцолбор дээр бүртгэхээр шийдвэр гарсан байгаа. Өөрөөр хэлбэл, автомашины худалдааг дагасан бүх үйлчилгээ тэнд цогцоороо бүрдэнэ гэсэн үг. Шинэ авто цогцолбор нь бүтээн байгуулалтыг улам өргөжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, замын хөдөлгөөний ачаалал, агаарын болон хөрсний бохирдлыг эрс бууруулан, нийслэл хотдоо иргэд таатай нөхцөлд тайван амгалан ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм. Авто Худалдааны Цогцолбор дээр 6375 авто зогсоол байдаг. Сул чөлөөтэй байгаа 5000 авто зогсоол дээр эхэлж ирсэн нь эхэлж байршлаа сонгох зарчмаар захиалга авч байна. Зогсоол түрээслэгчдэд 2017 оны аравсарын 01-ийг хүртэл авто зогсоолын түрээсийн төлбөрөөс чөлөөлөх хөнгөлөлттэй. Нийслэлийн Нийтийн тээврийн газраас "Авто машины цогцолбор"-ын чиглэлд автобус явуулж өгөх боломжтой гэсэн хариг бидэнд өгсөн байгаа. Одоогийн байдлаар 1300 гаруй автомашин худалдаалагчид ирчихсэн байна.

...Шинэ авто цогцолбор нь бүтээн байгуулалтыг улам өргөжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, замын хөдөлгөөний ачаалал, агаарын болон хөрсний бохирдлыг эрс бууруулан, нийслэл хотдоо иргэд таатай нөхцөлд тайван амгалан ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм...

...Бид гэр орноо барьцаанд тавин байж зээл аваад, гаднаас машин оруулж ирдэг. Хил, гааль дээр нь зохих татвараа төлж байгаа. Оруулж ирсэн машин чинь зарагдахгүй долоо, найм, цаашлаад 10, 20 ч хонож магадгүй....



Ц.Цэндсүрэн: Бид төр засгийнхны тоглоом болмооргүй байна

/Автомашин сэлбэгийн бизнес эрхлэгчдийн ҮЭХ-ны дарга/

-Өнөөдөр "Да хүрээ" захад автомашин борлуулж байгаа 30 гаруй мянган иргэн аж ахуй нэгжийг түшиглээд Баянзүрх дүүргийн 3,4 хорооны иргэд амьдралаа залгуулж байна. Автомашины чиглэлээр үйл ажиллагаа явуулж, дугуй, кузов засвар ажиллуулж байгаа. Зах дээр хоол хийж зараад, хэдэн төгрөг олчихож байна. Тэнд байгаа хүмүүс төрөөс юу ч гуйхгүйгээр амьдралаа залгуулж байгаа шүү дээ. Гэтэл "Да хүрээ" захыг нүүлгэхийг тэнд ажиллаж, амьдарч байгаа хүмүүс яах юм. Ядуучуудын эгнээнд шилжинэ биз дээ. Ажлын байрыг аваад явчихаж байгаа юм чинь яах билээ. Энэ мэтчилэн маш олон асуудал байгаа. Сүүлийн үед "Да хүрээ" зах нүүлчихлээ. Автомашины захууд цогцолбор руу нүүлчихлээ. Цогцолбор сайхан ажиллаж байгаа гэж мэдээлэл гаргаад байх шиг байна. Авто цогцолбор үйл ажиллагаа явуулж байгаа юу гэвэл тийм. Гэхдээ тэнд цэгцэрсэн юм алга. Зүгээр л шороо асгаад, дээрээс нь цементлээд л хаячихсан. Хэдэн чингэлэг аваачиж тавьсан байх. Өөр юу ч байхгүй шүү дээ. Тийм болохоор бид нүүхгүй. Яаж ч байсан нүүхгүй. Яагаад нүүхгүй вэ гэдэг шийдвэрийг бид гурван жилийн өмнөөс л тайлбарласан. Авто цогцолбор барьсан газар нь маш хүйтэн. Өвөлдөө -50 хэм хүрч хөрсөн дээрээ хүйтэрдэг гэж байгаа. Тийм газар машин тавихаар чинь хөлдөөд, асахгүй хэцүү биз дээ. Бид гэр орноо барьцаанд тавин байж зээл аваад, гаднаас машин оруулж ирдэг. Хил, гааль дээр нь зохих татвараа төлж байгаа. Оруулж ирсэн машин чинь зарагдахгүй долоо, найм, цаашлаад 10, 20 ч хонож магадгүй. Хүйтэн газар тавиад эвдэрчихвэл хэн хариуцлагыг нь хүлээх юм. Мөн Авто цогцолбороо цэвэрлэх байгууламжийн салхин дор барьчихсан. Хотын удирдлагууд нээлттэй байсан шүү дээ. Тийм газар яаж хүмүүсийг дасан зохиц гэж байгаа юм. Тэгээд тийшээ явах замыг нь шийдэж, өргөжүүлж, урсгалыг нэмнэ гээд байсан яасан бэ. Юу ч өөрчлөгдөөгүй байгаа. Та нар 24 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд, авто цогцолбор барьчихаад байхад нүүсэнгүй гээд байдаг. Тэгвэл автомашины бизнес эрхэлж байгаа 8000 гаруй иргэд, цаашлаад Баянзүрх дүүргийн 3, 4 хорооны иргэд тэр мөнгийг нөхөж өгөхийн тулд тийшээ нүүх болж байна уу. Тийм юм байхгүй. Бид одоо байгаа нөхцөлдөө орчноо сайжруулаад ажиллаж болно. Одоо болтол автомашины захуудыг нүүлгэх асуудал шүүхээр яригдаж байна. Эцэслэн шийдэгдээгүй байна. Ийм үед бид нүүхгүй ээ. Дээрээс нь бид төр засгийнхны тоглоом болмооргүй байна. Өнөөдөр "Драгон" авто вокзалын түгжрэл ямар байгаа билээ. Энэ авто тээврийн төвийг хотын гадна гарга л даа, тэгвэл. "Өгөөмөр" зах дээр орон нутгийн ачаа ачих гээд л том том машинууд ирээд, зам түгжрүүлдэг биз дээ. Тэр захыг гаргаач. Яагаад автомашин борлуулж байгаа иргэдийг ад үзээд байгаа юм. Би эцэст нь нэг зүйлийг хэлбэ. Тэр авто цогцолбор нь яг зураг төслийнхөө дагуу баригдаад, бүх шийдэх асуудал нь шийдэгдчихвэл нүүхэд хамаа алга. Тэр зураг төслийг нь та бүхэн хараарай. Зураг төсөл дээрээ олон сайхан барилгатай, дундаа нууртай, тэнд нь усны шувуу ирж буух маягтай л байсан биз дээ. Гэтэл одоо ямар байна. Тэнд юу ч алга. Хөлдүү, цэвдэгтэй газар л байгаа шүү дээ.


Сэтгүүлчийн дүгнэлт

АВТО ЦОГЦОЛБОРОО ОЛИГТӨЙХОН БАРЬЧИХ, ДАРАА НЬ "ХӨӨ"

Н.ПУНЦАГБОЛД

Нийслэлд авто худалдаа эрхэлж байгаа бизнес эрхлэгчдийг гурван жилийн өмнөөс л "ад үзэж" байгаа. Хотын зах руу гаргаж, нийслэлийн түгжрэлийг бууруулж, замын ачааллыг багасгах зорилготой л доо, уг нь. Тэгээд хотын баруун талд Авто худалдааны цогцолбор гээчийг барихаар болсон. Зураг төслийг нь харвал үлгэрийн ордон мэт харагдана. Дундаа нууртэй, эргэн тойрных нь талбай гял цал. Автомашины бизнес эрхлэгчид нүүгээд очвол бизнес нь цэцэглэж, сайн сайхан болохоор л харагддаг гэж байгаа юм. Тиймдээ ч хүн бүр л ам сайтай байж, автомашин импортлогчдыг хотоос гарах нь гэж найдсан байх. Гэтэл начин дээрээ юу болов. Авто цогцолбор гэдэг нь ердөө л нэг цементлэсэн талбай. Хэдэн чингэлэг. Бие засах газар гэхэд л төмөр чингэлэг байх жишээтэй. Тийм юм хийчихээд автомашин импортлогчдыг албадан нүүлгэх юм гэнэ лээ. 2015 оны намар, хүйтэн орох цагаар албадан нүүлгэх асуудлыг хөндөж байлаа. Уг нь автомашины захуудыг хотоос гаргах нь зөв. Ер нь авто машины зах гэлтгүй л хотоос гаргах зүйл маш их байна. Барилгын материалын зах, их, дээд сургуулиуд гээд л. Гэхдээ эхлээд авто захуудыг гаргахаар шийдээд, тодорхой хэмжээнд хөрөнгө оруулалт хийгээд, талбай ч болов засчихсан юм чинь ажлаа гүйцээх л хэрэгтэй юм. Зураг төсөлд үзүүдсэн шигээ л цогцолбор барьчих хэрэгтэй. Мөн баруун тийшээ явах замыг түгжрэл багатай болгох талаас нь ч ажлаа хийх л хэрэгтэй юм. Тиймгүй байж, хэдэн чингэлэг цэвдэгтэй газар аваачиж тавьчихаад машин зарж байгаа иргэдийг "хөөнө" гэвэл хэцүү л дээ. Албаны хүмүүс нийслэлд машин зарахыг зөвшөөрсөн нэг ч газар байхгүй гээд л яриад байна. Тийм л байх. Ер нь бол авто захыг хотоос гадагш нь гаргах, нүүлгэх, нийслэлийн ачааллыг багасгахыг хоёр гараа өргөн дэмжих хүн олон байгаа гэдгийг дахиад хэлбэ. Гэхдээ өөрийнхөө хөдөлмөрөөр амьдраад, улсад өч төчнөөн тэрбум төгрөгийн татварын орлого оруулж байгаа иргэдээ ингэж "хүчиндэж" болох уу. "Би чамд гэр өгнө" гэж амалчихаад, бүрээстгүй шалдан мод барьж өгөөд, энд амьдар гээд байгаагаар ялгаа юу байна. Асуудлын гол үүнд л байна. Дээрээс нь авто худалдаа эрхлэгчдийг хотоос гаргах асуудал одоо Захиргааны хэргийн шүүхээр хянагдаж байгаа юм билээ. Шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд л нүүх эсэх нь шийдэгдэнэ. Ямар ч шүүхийн шийдвэр гараагүй байхад нүүх мэдэгдэл тараагаад байгаа нь албаны хүмүүс хууль зөрчиж байна гэсэн үг. Тийм болохоор энэ жилдээ лав машин импортлогчид, ченжүүд хотоос гарахгүй нь. "Да хүрээ" ч нүүлчихгүй нь тодорхой байна. Ер нь бол Авто худалдааны цогцолбор байгуулна гэж цементэн талбай засаж, хэдэн чингэлэг байрлуулахад улсаас 24 тэрбум төгрөг зарцуулсан гэдэг. Тэр мөнгөө л нөхөх гээд байгаа нь үнэний ортой юм биш үү. Нөгөө талаар худалдаа эрхлэгчдээс мөнгө босгоод, түүгээрээ зураг төсөл дээрх шиг цогцолбор бий болгох төлөвлөгөөтэй талаар ч ярьж буй. Хэчнээн ч жилийн дараа тэр нь босох юм. Тэр хооронд авто худалдаа эрхлэгчид нь яах болж байна. Ингэж хүчиндэж болохгүй ээ. Эхлээд бүх зүйлээ ном журмаар нь хийчих. Барилга байшингаа барь. Замынхаа асуудлыг шийд. Тэгээд дараа нь захаа хотоос гарга. Энэ төсөл анх яригдаж байхад хятадууд авто худалдааны цогцолборыг чинь бариад өгье гэсэн санал тавьж байсан талаар зарим хүмүүс ярьдаг. Хоосон талбай руу бизнес эрхлэгчдээ хөөж байхаар гадаадаас зээл, тусламж аваад, асуудлаа нэг мөр шийдчихээд, эргээд орж ирэх мөнгөөр нь төлөх хувилбар, боломж байгааг судалж болдоггүй юм уу.

ДЭЛХИЙ



Японы гүнж харц залуутай сүй тавьж буйгаа албан ёсоор зарлав

Японы эзэн хаан Акихитогийн ач нарын хамгийн ахмад нь болох гүнж Мако их сургуульд хамт сурдаг оюутан залуу Кэй Комүротой албан ёсоор сүй тавьж буйгаа зарлалаа.

Гүнж, сүйт залуугийнхаа хамт Токно дахь Акасака ордонд хэвлэлийн бага хурал зарлаж, энэ үеэрээ сүй тавих эзэн хаан Акихитогийн зөвшөөрлийг авч чадсандаа баяртай байгаагаа илэрхийлсэн байна. Тэд хоёул 25 настай ажээ. Хосууд 2012 онд Токногийн Олон улсын христийн шашины их сургуульд оюутан байхдаа анх

танилцсан бөгөөд таван жилийн турш үерхсэн байна. Японы хэвлэл мэдээллийн хэрэгслээр өнгөрсөн тавдугаар сарын дундаас эхлэн хосуудын талаар шуугиж эхэлсэн юм. Гүнж Мако сүй тавих гэж байгаа нь япончуудын хувьд томоохон үйл явдал юм. Сүй тавих улмаас албан ёсны зарыг долдугаар сард гаргахаар төлөвлөж байсан ч, Япон улсын баруун өмнөд нутагт нүүрлээд байсан хүчтэй аадар борооны улмаас хойшлуулсан байжээ. Гүнж Мако нь Токногийн музейд судлаач хийдэг бол Комүро нь хууль зүйн фирмд туслах ажилтанаар ажилладаг аж.

Одоогоор бизнесийн хуулийн чиглэлээр магистрийн зэрэгт сурч байгаа юм байна. Мако нь Эзэн хааны титэм залгамжлах ханхүү Нарухитогийн дараа орох Японы эзэн хааны хоёр дахь хүү, ханхүү Акишиногийн том охин юм. Макогийн уг гэрлэлт нь эмэгтэйчүүд хааны удмын бус хүнтэй гэрлэсний улмаас өөрийн ихэс дээдсийн байр сууриа алдах, хоёрдугаар зэргийн төрөл саданг хүлээн зөвшөөрдөггүй хааны гэр бүлийн 1947 оноос хойш дагаж мөрдөж ирсэн хуулийг дахин шинэчлэхэд хүргээд байгаа аж.

Их Британийн гүнж Кэйт Миддлтон жирэмсэн болжээ

Их Британийн эзэн хааны ордноос ханхүү Уильямын гэргий гүнж Кэйт Миддлтон жирэмсэн болсон талаар өчигдөр албан ёсоор мэдээллээ. Эдүгээ 34 настай Кэйт гурав дахь хүүхдээ тээж буй нь энэ юм. Эзэн хааны ордноос мэдээлсэнээр, гүнжийн хөл хүнд болсон мэдээг хатан хаан хоёрдугаар Элизабет сонсоод туйлын их баярласан гэнэ. Сүүлийн өдрүүдэд барууны хэвлэлд гүнжийг жирэмсэн болсон гэх мэдээлэл гарч байсан ч, ордноос хараахан

батлаагүй байсан юм. Харин өчигдөр хийсэн мэдэгдэлдээ ийнхүү баталжээ. Гэвч, гүнжийн биеийн байдал тааруу байгаа бөгөөд эмчилгээ хийлгэж буй ажээ. Улмаар эрүүл мэндийн шалтгааны улмаас ойрын өдрүүдэд олон нийтийн үйл ажиллагаанд оролцохгүй гэсэн байна. Их Британийн нийслэл Лондон хотын сургуульд энэ долоо хоногт зочилсон Уильямын том хүү Жорж ханхүү, Шарлотт гүнж нар ч дүүтэй болно гэх мэдээг сонсоод тун их баярласан аж.

БНХАУ агаарын бохирдыг эсрэг тэмцэж эхэллээ

Хятадын Байгаль орчны яамнаас намар болон өвлийн туршид агаарын бохирдлын эсрэг арга хэмжээ авч үйл ажиллагаа явуулах болсноо зарлажээ.

Хятад улс нь урьдчилан тооцоолох хүчин чадлыг 7-10 хоног болгон нэмэгдүүлснээр үр дүнтэй урьдчилсан арга хэмжээ авахад хангалттай хугацаа гаргаж өгч байна гэж Байгаль орчны яамны мэдэгдэлд дурьджээ.

Үр дүнтэй арга хэмжээ авахын тулд Хятадын хойд болон төвийн бүс нутгуудаар байрлах нийт 28 хотын ослын үеийн төлөвлөгөөг сайжруулах шаардлагатай байгаа юм.

Их хэмжээний агаарын бохирдол үүссэн үед, судалгааны багийнхан тус бүсийн ослын үеийн арга хэмжээг сайжруулан ажиллах бөгөөд хэрэв бүсүүдэд их

хэмжээний агаарын бохирдол гарахыг урьдчилан тогтоож чадвал Байгаль орчны яамнаас мэдэгдэл гарган хамтарсан арга хэмжээнүүдийг авах аж.

Мөн Бээжин-Тяньжин-Хэбэй мужууд хамтран агаарын бохирдлын эсрэг ажиллах байгаль орчны агентлагийг байгуулан намар, өвлийн туршид уг асуудалтай тэмцэх арга хэмжээ авахаар болжээ. Хятад улсын хувьд зөвхөн авто машины зөвшөөрөл олгох, дахин үзлэгт оруулахаас эхлүүлээд үйлдвэрийн газруудад гаргаж болох бохирдлын хэмжээг багасгадаг. Мөн шинээр суурилуулж буй цахилгааны эх үүсвэрээ сэргээгдэх эрчим хүчний үүсвэр рүү хурдацтайгаар шилжүүлж байгаа нь цаашид гарах бохирдлын хэмжээг багасгахад ихээхэн нөлөөлдөг ажээ.

Энэтхэгийн Батлан хамгаалахын сайдаар эмэгтэй хүн томилогдов

Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модри Батлан хамгаалахын шинэ сайдыг томилжээ. Ингэхдээ эмэгтэй хүнийг сайдаар томилсон нь дэлхий нийтийн анхаарлыг татсан юм. Тэрбээр Нирмала Ситараман гэх эмэгтэйг Энэтхэгийн батлан хамгаалах яамыг удирдуулахаар сонгосон байна. Энэтхэгийн Засгийн газарт түүнээс гадна таван эмэгтэй сайд багтдаг аж.

Энэтхэг нь Хятад болон Пакистан улстай хилийн маргаантай байгаа. Хятад улс нь Гималайн нурууны бүс дэх стратегийн ач холбогдолтой бүсэд хоёр улсын хилийн цэргүүдийн хооронд олон сар үргэлжилсэн зөрчлийг зогсоохоор зөвшөөрсөн юм.

Үүний зэрэгцээ өнгөрсөн наймдугаар сард 10 хүн амь үрэгдсэн галт тэрэгний осолд хариуцлага хүлээн төмөр замын сайд огцрох өргөдлөө өгснийг Нарендра Модри хүлээн авчээ. Нарендра Модри 2014 онд Энэтхэгийн ерөнхий сайдаар сонгогдсоноос хойш анх удаа их халаа сэлгээ хийж, есон сайдыг сэлгэсэн байна.



Б.СУМБЯА

НҮБ-ын Аюулгүйн зөвлөл, олон улсын нийгэмлэгийн зүгээс тавьж буй шаардлагыг үл ойлгож, Хойд Солонгос улс ням гарагт устөрөгчийн бөмбөг туршсанаа мэдэгдсэн билээ. Тэгвэл эл туршилтын дараа агаар мандалд ямар нэг цацраг идэвхит туяа бүртгэгдээгүй талаар Хятад, Япон улсын албаныхан өчигдөр мэдэгдлээ.

Тус цөмийн зэвсгийн газар доорх дэлбэрэлтээс алдагдсан хорт туяа агаар мандалд тархах вий гэсэн айдас хил залгаа улс орнуудын санааг зовоож байсан юм. Ням гарагийн туршилтын дараа Япон даяар ажиллаж байгаа агаарын хяналтын байгууламжуудад ямар нэг онцгой зүйл бүртгэгдээгүйг тус улсын засгийн газрын төлөөлөгч Ёшихидэ Суга мэдэгджээ.

Хятадын байгаль орчны яам мөн Хойд Солонгосын хил орчмын агаар мандалд нөхцөл байдал хэвийн байгааг мэдээлсэн юм. Тус яамны вэб сайтад "Хойд Солонгосын цөмийн туршилтадоогоор манай

...Эхний дэлбэрэлтээс ердөө найман минутын дараа болсон хоёр дахь дэлбэрэлт нь туршилт явуулсан хонгилын системийн эвдрэл байж магадгүй хэмээн мэргэжилтнүүд сэжиглэж байжээ...

улсын байгаль орчин, хүн амд ямар нэг нөлөө үзүүлэхээргүй байгаа нь хэмжилтээс харагдаж байна" гэсэн байна. Түүнчлэн, Японы батлан

хамгаалахын сайд Ицунори Онодера агаар мандал дахь цацраг идэвхийн хэмжээг тодорхойлох багажтай нисэх онгоцнууд хөөргөхөөр бэлдэж байгаагаа мэдэгджээ.

Хойд Солонгосын устөрөгчийн бөмбөгийн туршилтын үеэр дараалсан дэлбэрэлт бүртгэгдсэн байдаг. Энэ нь бүс нутгийнхныг болгоомжлоход хүргэж байв. Эхний дэлбэрэлтээс ердөө найман минутын дараа болсон хоёр дахь дэлбэрэлт нь туршилт явуулсан хонгилын системийн эвдрэл байж магадгүй хэмээн мэргэжилтнүүд сэжиглэж байжээ. Хэрвээ ийм зүйл тохиолдсон бол цацраг идэвхит бодис алдагдах аюултай юм байна. Зургаа дахь удаагаа зохион байгуулсан Хойд Солонгосын цөмийн туршилт урьд өмнөх туршилтаудаас олон дахин хүчтэй болсон гэгдэж байгаа. Тухайлбал тав дахь туршилтаас 5-6 дахин, дөрөв дэх туршилтаас 11 дахин хүчтэй болсныг мэргэжилтнүүд хэмжсэн байна.

Тэгвэл Хойд Солонгосын

эл туршилтаар холбогдуулан Өмнөд Солонгос ч мөн ням гарагийн орой пуужингийн туршилт хийсэн юм. Тэд туршилтын талбайгаас Хойд Солонгосын цөмийн зэвсгийн хөгжүүлэлт хийх талбай хүртэлх зайг хэмжиж, түүнтэй яг ижил зайтай байг Япон тэнгист байршуулан "Хэнму" гэх богино зайн тусгалт баллистик пуужинг туршсан байна. Тус улсын цэргийн албаныхны мэдээлээр пуужин яг байндаа тусчээ. АНУ-ын Цагаан ордон ч гэсэн Пхеньяны цөмийн туршилтаар холбоотойгоор байр сууриа илэрхийлээд байгаа билээ. Тэд өөрийгөө болон холбоотнуудаа хамгаалахын тулд Хойд Солонгосын эсрэг цөмийн зэвсэг ашиглахад бэлэн гэдгээ мэдэгдээд байгаа юм. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Японы Ерөнхий сайд Шинзо Абэтэй утсаар ярихдаа энэ тухай мэдэгдсэн аж. Ямартай ч, Пхеньян зургаа дахь удаагийн цөмийн туршилтаа хийсэнтэй холбоотойгоор бүс нутгийн байдал улам хурцдаад байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас доорх үл хөдлөх эд хөрөнгийн анхны албадан дуудлага худалдааг 2017 оны 9 дүгээр 22-ны өдрийн 10:00 цагт зохион байгуулна.

Д/д	Эд хөрөнгийн байршил	Хэмжээ	Зориулалт	Байршил	Харилцан тохиролцож тогтоосон, үнэлгээчний тогтоосон үнэ	Дуудах үнэ Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.4-д заасны дагуу харилцан тогтоосон, нэлгээчний тогтоосон үнийн 50%	Шийдвэр гүйцэтгэгч
1	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Баянхайрхан багийн 18 дугаар байрны ард хаягт байрлах эзэмших эрхийн улсын бүртгэлийн 103607 дугаартай гэрчилгээтэй, дэлгүүр, орон сууцны зориулалттай газар, улсын бүртгэлийн Y-0518001098 дугаар бүртгэгдсэн, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000151281 дугаар гэрчилгээтэй, орон сууц, дэлгүүрийн зориулалттай барилга	Газар 96 м2 Орон сууц, дэлгүүр 90 м2/гал тогооны хамт 3 өрөө/ 34м2 2 өрөө	Дэлгүүр орон сууцны зориулалттай газар, орон сууц, дэлгүүр	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Баянхайрхан багийн 18 дугаар байрны ард хаягт байрлах	52.621.394	36.834.975	Б.Шөгмэд 89086020
2	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Баянхайрхан баг 6 дугаар гудамж 16 тоот хаягт байрлах улсын бүртгэлийн Y-0518001001 дугаартай, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000139534 дугаар гэрчилгээтэй хашаа	530,8 м2	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Баянхайрхан баг 6 дугаар гудамж 16 тоот	3.129.384	2.190.568	Б.Шөгмэд 89086020

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Оргил баг Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хурлын зааланд болно.
Жич: Дэнчин болох үнийн дүнгийн 10 хувийг 2017 оны 09 дугаар сарын 21-ны өдрийн 13:00 цаг хүртэл албаны дансанд бэлнээр тушааж, бүртгүүлсэн байна.
Харилцах утас: 89086310, 89086020

НИЙГЭМ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

Б.ДАВААХҮҮ

Хэзээ, хэн углаж байсан нь мэдэгдэхгүй майжнийж, хоншоор нь эргэсэн хуучин гуталнууд, хэн тоглож байсан юм бол гэмээр халтар хүүхэлдэй, ноорхой чихмэл, одон медаль, тогооны таг, сэтгэхий шаазан аяга, будаа агшаагчны сав гээд ёстой л нөгөө “Ногоон хурганы арьс, нохойн битүү туурайнаас бусад нь байна” гэдэг шиг зүсэн зүйлийн хог новш “Хархорин” захын автобусны буудалтай хаяа дэрлэн хөглөрнө. Гэхдээ тэр бүх зүйл хог биш, хэрд таарсан үнээр худалдаалдаг “бараа” юм.

нэн даруй зогсоох мэдэгдэл хүргүүлж, шаардлагыг үл биелүүлэн хууль зөрчсөн худалдааг албадан зогсоох арга хэмжээг авч буй аж.

Хууль зөрчигчид төрийн шийдвэрийг уяндаа гишгэсээр байх уу

Өнөөдрийн байдлаар Хархорин зах, Хорооллын нийтийн эзэмшлийн явган хүний зам талбай чөлөөлөгджээ. Манай сурвалжлах хэсэг өчигдөр дээрх



НИЙТИЙН ЭЗЭМШИЛТИЙН ТАЛБАЙ ХЭСЭГ БҮЛГИЙН ЭЗЭМШИЛ БИШ БАЙЛТАЙ

Автомашин хүнгэнэх чимээ, микро автобусны кондукторын орилох дуу, хоорондоо чанга ярилцах хүмүүс гээд хонь хурга нийлсэн мэт шаагидана. Басхүү хаанаас хэн түүж ирсэн, хэр удаан хадгалсан нь мэдэгдэхгүй төрөл бүрийн жимсийг цаасан хайрцаг дээр уутлан зарах аж.

“Ажлын байр”-ндаа тамхи баагуулж, хагархай хэнгэрэг шиг зогсоо зайгүй угсаар ярих эмгэгтэй. Нэгнийхээ наймаанд саад боллоо гэх шалтгаанаар амаа урах шахан хэрэлдэх эр, эм. Уусан сархаддаа хөлчүүрхэн төмөр хашаа руу сэжм ч үгүй “сарих” согтуу эр. Баригдаж буй барилгаас тусгаарлах төмөр хашааны ёроол нус, цэр, бөөлжис, тамхины иш, хогоор дүүрч, зөрж өнгөрөх хүмүүсээс хир даг, архины эхүүн үнэр ханхлах нь цөөнгүй. Хаа нэг салхи сэвэлзэхэд шээс, шивтэрийн үнэр сэн хийж, хамар цоргино. Энэ бол “Хархорин” захын хойд талын нийтийн эзэмшлийн явган хүний замын нийтлэг нэгэн төрх. Угтаа энд жижиглэнгийн худалдаа эрхлэхийг хориглодог юм билээ. Гэвч, нийтийн эрх ашгаас өөрийнхөө эрх ашиг, өнөөдрийн ашгаа илүүд үзсэн худалдаачид хувьдаа эзэмшин худалдаа эрхэлнэ.

Ил задгай худалдаа эрхлэгчдийн цар хүрээ БГД-ийн 20 дугаар хороо, “Барс 2” худалдааны төвөөс зүүн тийш Хархорин хороолол хүртэл, төв замын хойд хэсэг буюу СХД-ийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэр 19 дүгээр байрны урд талын автобусны буудлын ойр орчмыг хамрах аж. Байдал өнөөдрийг

хоёр талбайг зорьсон юм. Юун түрүүнд Хархорин захыг зорилоо. Өмнө нь ажиглагддаг өнөөх хог новш энэ удаад ор мөргүй алга болжээ. Гэхдээ талбайн хэд хэдэн хэсэгт хуучин гутал, хувцас, самар худалдаалж буйтай таарлаа. Гар дээрх худалдаа эрхлэгчдээр дүүрч байсан талбай чөлөөлөгдөн цэийж байв. Захын ойролцоо “Эрин” хороололд амьдардаг 30 гаруй насны болов уу гэмээр бүсгүйг Ц.Маргад гэдэг. Тэрбээр энд нүүж ирээд жил гаруй болж буй аж. Ц.Маргад “Энэ хавиар явахад хэцүү байдаг байсан. Согтуу, хөлчүү хүмүүс ихтэй. Би явган хүний замаар явж чаддаггүй, шороон замаар явбал амар байдаг. Манай хорооллын булан тохой, хүүхдийн тоглоомын талбай гэх мэт ойр орчимд архи ууж, ил задгай бие засаад сууж байгаа хүмүүс мөрг, сэр харагддаг. Зам чөлөөлөгдсөн чинь амар байна. Гэхдээ өнөөдөр даваа гараг учраас задгай худалдаа эрхлэгчид цөөрсөн байх. Маргаашнаас эрхлэгчид л гараад ирэх вий дээ. Төр, засгаас нэгэнт нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлж байгаа бол чөлөөлсөн шиг чөлөөлөх хэрэгтэй болов уу” гэлээ.

III, IV дүгээр хорооллын явган хүний замын ил задгай худалдаа эрхлэгчид ч дөөрчээ. Өмнө нь харж байгаагүй мэт цэцгийн мандал, явган хүний сандал тэнд ярайж байлаа. Худалдаа эрхлэгчид иргэдийн хөлөө амраах сандал,

худалдаа эрхлэх иргэд, Хархорин захын автобусны буудалд ил задгай худалдаа эрхлэгчид Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар руу дайран оржээ.

Басхүү гадаах талбайд нь өөрсдийн хувийн эрх ашгийн төлөө эсэргүүцлийн жагсаал хийж байлаа. “Газар бол ард түмний өмч”, “Баривчилдаг цаг 1930-аад он биш” гэх мэт үгсийг бичсэн уриа лоозон барьж, цагаан хоолой барин хашгирч байв. Цагдаа нар, албаныхан тэдэнтэй уулзан учир байдлыг лавлахад тэд үл ойшоон, шүтэл үлээн шуугилдана.

Улмаар Баянгол дүүргийн Засаг даргын өрөөний хаалгыг эвдэнэ хэмээн ганхайрч, биднийг гадна талбайд худалдаа хийлгэ хэмээн эрээ цээргүй аашлав. Тэд хэнийг ч үл сонсоно.

Чухам ямар учраас ийн аашилж буйг нь асуухад “амьдрал хүнд байна” гэх ганц хариултаар ам таглана.

Хархорин захын гадна худалдаа эрхлэгч Сонгинохайрхан дүүргийн иргэн Б “Бид Хархорин захын гадна худалдаа эрхэлдэг. Биднийг хөөж, туугаад зогсоохгүй учраас дүүрэг дээрээ ирээд хэмээн эрээ цээргүй аашлав. Үр хүүхдээ тэжээмээр байна. Улс орон ажил өгөхгүй байна. Маш хэцүү байна. 10-аад хоногийн өмнөөс лангуунуудыг буулгаад, худалдаа эрхлэгчдийг хөөж, тууж

шүтэл үлээж байлаа. Тиймээс үүсэснээх хөлбидлын талаар Баянгол дүүргийн Хүнс, худалдаа, үйлдвэр үйлчилгээний хэлтсийн дарга Э.Сансараас дараах тодруулгыг авлаа.

Э.Сансар: Төрийн албан хаагчийн биед дур зоргоороо халдаж байна

/Баянгол дүүргийн Хүнс, худалдаа, үйлдвэр үйлчилгээний хэлтсийн дарга/

–Нийслэлийн Ерөнхий менежерийн захирамжийн дагуу ил задгай худалдаа эрхлэгчдийн лангуут албадан буулгаж эхэлсэн. Энэ үеэр маргаан, үймээн болсон гэсэн мэдээлэл байгаа. Тэнд ажиллаж байсан хүний хувьд та нөхцөл байдал ямар байсан талаар тодруулахгүй юу?

–III, IV дүгээр хорооллын орчмын худалдаа эрхлэгчдийн хувьд эсэргүүцэл үзүүлээгүй. Дийлэнх нь ойролцоох томоохон дэлгүүрээс бараагаа татдаг учраас дэлгүүр онгойхоор бараагаа зөөнө гэдгээ илэрхийлсэн. “Ямар ч байсан лангуугаа хураа” гэсэн шаардлага тавьсан, хураасан. Эргэн тойронд цөөн тооны зөвшөөрөлгүй ТҮЦ байсан. Ээдийг нь дуудаж, шаардлага тавихад өөрсдөө ачаад явсан. Нэг л хэсэгт маргаан үүссэн юм. Тэр нь Д.Цэцэгэгийн хариуцагч том цагаан асар. Асрын түрээслэгчид нь нийтдээ 30 орчим хүн байна билээ. Тэд “Бид Д.Цэцэгэд сарын 300-500 мянган төгрөгийн түрээс төлдөг. Түрээсийнхээ мөнгийг төлчихсөн атлаа үйл ажиллагаагаа зогсоож чадахгүй” гэдгээ бидэнд хэлж байсан. Харин иргэн Д.Цэцэгэгийн тухайд өмнө нь манай дүүргийн Засаг даргатай ч уулзаж байсан хүн. Түүнд, өмнө нь хэд хэдэн удаа нийтийн эзэмшлийн талбайд худалдаа эрхлэж болохгүй, таслан зогсоо гэсэн шаардлага тавьж байв. Тэр бүрт “Өөрөө асраа буулгачихъя, хүмүүсээ дуудаад бараагаа хураана” гэж хэлдэг байсан ч маргаан үүсэх үед дотор нь ажиллаж байсан хүмүүсээ турхирч эхэлсэн. Түүнээс болоод төрийн албан хаагчид, хууль хяналтын байгууллагынхан болон тус асарт түрээс төлж худалдаа эрхлэж байсан иргэдийн хооронд маргаан үүссээ. Нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлөх ажлын хэсгийн ахлагчаар Засаг даргын орлогч Батбилэг ажиллаж байгаа. Би ажил үүргийнхээ хүрээнд тэнд ажиллаж байсан хэрэг. Гэтэл гэнэт л худалдаа эрхлэгчид бослого гаргаж, учир зүггүй бүгд дайрч эхэлсэн. Бүгд л над руу “асуудал шийдэж өг” хэмээн дайрч, түлхэх нэг нь түлхэж, чимхэж байлаа. Тэр бүх үйл явцыг цагдаа нар камерт бичиж авсан. Нийслэлийн ерөнхий менежерийн тушаалыг аль нэг дүүргийн хэлтсийн дарга зогсоох, түдгэлзүүлэх эрхзүйн үндэс байхгүй шүү дээ. Миний хэр хэмжээнээс хэтэрсэн шаардлага тавьж байгаа нь

тэдэнд учирласан ч, ойлгоогүй.

Тэр үйл явцын өмнөхөн Хархорин захын ил задгай худалдаа эрхлэгчид хороололд ирсэн юм. Дүүрэгт удирдлагууд байдаг гэдэг утгаар. Тэгээд биднээс нийслэлийн Ерөнхий менежерийн тушаалыг аваад явсан. Гэтэл III, IV дүгээр хорооллынхон бидний ажлыг ойлгохгүй, бас намайг явуулахгүй “Эндээ байж байгаад бидний асуудлыг шийд” гэх шаардлага тавьж байсан.

–Түр хугацаанд газар чөлөөлөлтийг зогсоосон гэсэн. Үймээнээс болсон хэрэг үү?

–Тэр үймээний дараа ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байгаа Батбилэг дарга худалдаа эрхлэгчдийн зүгээс тавьсан есдүгээр сарын I-ний өдөр хүртэл худалдаа эрхлэе гэсэн хүсэлтийг хүлээж авсан юм. Тэгээд газар чөлөөлөх ажиллагааг хоёр өдрөөр сунгасан хэрэг. Гэтэл өнөөдөр /өчигдөр/ өглөө 08:30 цагт миний ажлын өрөө рүү III, IV дүгээр хорооллын 20 гаруй худалдаа эрхлэгч дайрч орж ирсэн.

Миний хувьд “Та нар албан ёсоор уулзах хүсэлт гаргавал хурлын танхим бэлдэж, холбогдох удирдлагатай уулзуулна шүү дээ” гэж хэлсэн боловч, огт тоогоогүй. Тэнд үнэндээ учир зүйгээ ололцоё, шийдье гэсэн хүн байхгүй юм шиг байсан. Бүгд л өрөөнд дайрч орж ирээд зэрэг орилчихсон. Миний хоолой тэдний дууг давахгүй юм билээ. Манай Захиргаа, хуулийн хэлтсийн албаны дарга тайлбар хийсэн ч тоогоогүй. Тамгын газрын дарга хүртэл үүссэн асуудлыг зохицуулахыг хичээсэн боловч, бүгд л учир зүггүй дайрч, цохихоор гараа далайж байсан. Аргагүйн эрхэнд цагдаа нар ирж, асуудлыг зохицууллаа. Тэд төрийн албан хаагчид дур зоргоороо халдаж байна.

–Нийтийн эзэмшлийн газар чөлөөлөлтийг оршин суугчид яаж хүлээж авч байгаа бол?

–Оршин суугчид талархлаа илэрхийлж байгаа. Өнөөдөр гэхэд III, IV хорооллын томоохон худалдааны төвийн төлөөлөл гээд 4-5 хүн ирсэн. Дүүргээс нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх ажил хийж байгааг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Ил, задгай худалдаа эрхлэгчдийг холдуулчихвал өөрсдийн байгууллагаас 50 метр хүртэлх зай талбайг өөрсдийнхөө хөрөнгөөр тохижуулаа, ногоон байгууламж тарья гээд зураг төслөө хүртэл гаргасан байсан. Нийслэл даяар ийм арга хэмжээ авч байгаа. Бусад дүүргүүдийн тухайд асуудлаа шийдчихсэн. Манай дээр л ийм асуудал үүсээд байна.

Оршин суугчдаас мөнхийн гомдол ирдэг. Тэр орчмын оршин суугчид нь албадан лангуунуудыг буулгаж эхэлсний дараа дүүрэг дээр ирж талархал илэрхийлсэн. Яагаад зогсоочихов үргэлжлүүлээч гэсэн хүсэлт тавьж байсан. Чиг үүргийнхээ хүрээнд цагдаагийн хэлтэс хяналт тавьж ажиллана.


–Хархорин захын худалдаа эрхлэгчид эсэргүүцлийн жагсаал хийж байна. Тэр хавийн лангуут хэзээ буулгасан

бэ? –Наймдугаар сарын 2-нд дүүргийн Засаг даргын ил задгай худалдааг цэгцлэх захирамж гарсны дагуу ажлын хэсэг гарсан юм. Эхэндээ Хар хорин захын худалдаа эрхлэгчид зөвшөөрөлгүй ТҮЦ, контейнрээ холдуулчихвал өөрсдөө буучихъя гэсэн шаардлага тавьж байсан юм. Тэр шаардлагыг биелүүлэхэд тодорхой хэмжээний зардал гарахаар байсан. Улмаар дүүргийн Засаг даргын ноёд хөрөнгөөс шаардагдах хөрөнгийг шийдэж, зөвшөөрөлгүй байрлуулсан 16 контейнр, хоёр шавар байшинг албадан буулгаж газрыг чөлөөлсөн. Тэгээд эргэн тойрных нь хогийг цэвэрлэхэд зөвхөн тэр орчмоос 3.5 тонн хог хаягдал гарсан. Хогийг нь цэвэрлэж, газрыг цэгцэлснийхээ дараа “Одоо та нар үйл ажиллагаагаа зогсооно уу” гэсэн ч, тэд үгүй гэсэн. Ерөнхийдөө газар чөлөөлөлт эхлэхээс өмнө Хархорин захын 40-50 иргэнийг дүүргийн Засаг дарга хүлээж авч үүлзсэн юм.

Тэр уулзалтын үеэр “үйл ажиллагаагаа үргэлжлүүлье” гэсэн хүсэлт тавьж байлаа. Бидний тухайд ямар ч боломжгүй гэдгийг тайлбарлаж хэлсэн. Сүүдрэвчтэй худалдаа гэдгээр манайд байхгүй. Ямар нэг худалдааны төв байгуулагдлаа гэхэд, заавал нийслэлийн Засаг даргын захирамжтай газарт байгуулах ёстой. Стандартын шаардлага хангасан бараа таварыг хадгалах шаардлага хангасан орчинтой байх ёстой шүү дээ. Тэгээд боломжтой газруудад зуучилъя. Түрээсийн асуудал хүнд байгаа нэг, хоёр сарын түрээсийг нь хөнгөлөө талас нь ярья гэж хэлсэн. Ингээд бүртгүүлчих гэхэд бүгд бүртгүүлэхгүй гээд гарсан.

–Биднийг ирэхэд хэсэг хүмүүс Засаг даргын өрөө рүү хүч түрэн орж байсан. Тэд ч бас худалдаа эрхлэгчид хэрэг үү?

–Тийм ээ. Тэд чөлөөлсөн нийтийн эзэмшлийн талбайг бидэнд олго. Бид тэнд сүүдрэвч бариад худалдаагаа хийе гэсэн санал тавьж, гадаа жагсаал хийж байгаа. Тэр хүсэлтийг нь хүлээж авах эрхзүйн үндэслэл байхгүй. Дүүрэг жижиг, дунд худалдаа эрхлэгчдийг дэмжинэ. Гэхдээ хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж буй худалдаа эрхлэгчдийг л дэмжинэ. Үүнийг тайлбарлаж хэлсэн ч, өнөөдөр /өчигдөр/ манай байрны гадна жагсаал хийж байна. Үдээс хойш 13:00 цагийн үед биднийг зөвлөлийн хурал хийж байхад 20-30 хүмүүс хүч түрж орж ирсэн. Үүдэнд байсан туслах ажилтныг түлхэж унагаагаад үүд хаалга саваад дайрч орж ирнэ лээ. Одоогоор лоозонгоо бариад л зогсож байна. Энэ бол 10-20 хүний л асуудал. Хархорин зах хоёр, гурван мянган түрээслэгчтэй. Тэр түрээслэгчид зохих татвараа төлөөд, нийгмийн өмнө харуцлага хүлээгээд ажиллаж байгаа. Тэр хүмүүс эднээс болоод орлогоо алдсан. Бидэнд байнга гомдол гаргадаг. Оршин суугчид нь байнга гомдол гаргадаг. Хороолол ч гэсэн мөн л 20, 30 хүний асуудал байгаа.



хүртэл ийм байв. Тэгвэл эдүгээ байдал өөрчлөгджээ.

Улаанбаатар хотын Ерөнхий менежер наймдугаар сарын 25-ны өдөр А/134 тоот тушаал гаргаж, гар дээрээс худалдаа эрхлэгчдийн лангуут албадан буулгаж, чөлөөлөх ажлыг тухайн дүүрэг бүрт нь хариуцуулсан байна. Ингэснээр нийтийн эзэмшлийн гудамж талбайг чөлөөлөх ажлыг дүүргийн цагдаагийн алба хаагчид, нийслэлийн мэргэжлийн хяналтынхан болон ТҮК-ийнхэн хариуцан ажиллаж эхэлсэн байдаг.

Ерөнхий менежерийн тушаал ёсоор Хархорин захын орчмын задгай худалдаа эрхлэгчдийн лангуут Баянгол дүүргийн холбогдох албаныхан албадан буулгаж эхэлжээ. Мөн III, IV хорооллын 1000, 10000 нэрийн барааны дэлгүүр, Москва их дэлгүүр орчмын гар дээрээс баруу бүсэд зогсох боруулах худалдаачдад үйл ажиллагаагаа

цэцгийн мандлыг эзэлдэг байсан учраас тэнд ямар бүтээн байгуулалт хийгдсэнийг ч иргэд мартаж дөхсөн байж.

Хэдий жижиг-лэнгийн худалдаа эрхлэхийг хориглосон ч тэнд хэд хэдэн цэгт хүмүүс ирж, лангуугаа засч харагдсан юм. Тэдний зарж буй бараа Хархорингийн өмнөх худалдаачдыг бодвол шинэ юм билээ. Тэгдээр худалдаа эрхлэгчид улсын төсөвт татвар, аль нэг байгууллагад түрээс төлдөггүй. Тийм атлаа нийтэд зориулагдсан талбайг үнэ төлбөргүйгээр хувьдаа ашиглан, басхүү төрийн шийдвэрийг үл ойшоох аж.

Учир юу вэ гэвэл, өөрийн бизнесийг нь хориглосон гэх шалтгаанаар III, IV дүгээр хорооллын орчимд жижиглэнгийн

эхэлсэн. Ер нь бол байдал хэцүү байна. Бүх хүмүүс л банк, өдрийн зээлтэй. Би гутал пүүз зардаг. Хархорин захын орчимд 120 орчим хүн гадаа жижиглэнгийн бараа зардаг. Түрээслэх байр, лангуу алга. Байсан ч түрээс нь өндөр. Эргэлтийн хөрөнгө бага учраас тэр бүр түрээс төлж чаддаггүй” гэж ярилаа. Түүнтэй цөөн хором ярилцахад Засаг даргын Тамгын газрын үүдэнд цугласан 40 гаруй эмэгтэйчүүд голдуу худалдаа эрхлэгчид юу хэлж буй нь үл мэдэгдэм ам амандаа хашгирагдаж байсан юм. Харин зарим нь учир утгагүй

ЗАВСАРЛАГА



ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +23
Шөнө +9

Нөгөөдөр
Өдөр +17
Шөнө +7

Өдрийн зурхай

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал арвидна..

Наран ургах, шингэх:

06.21-19.25



Аргын тооллын 9 сарын 5, Ангараг гараг. Билгийн тооллын 14, Чөдөр одтой, хөхөгчин хонь өдөр. Өдрийн наран 6 цаг 21 минутад мандан, 19 цаг 25 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

Үргэлжлэл.

Түүрүүч нь №146, 147 дугаарт

Клиндрифт огт өөрчлөгдөөгүй байхад Жемин тэс өөр ондоо хүн болсон байв. Түүнийг хотын гудамжаар өнгөрөн Ван Дер Мервегийн дэлгүүрийн дэргэд очиж зогсоход хүмүүс хойноос нь харцгааж байлаа. Үнэтэй сайн морь, тэрэг тэдний анхаарлыг татсан хэрэг бус залуу эрийн баяр баясгалант царайг хараад гайцгаажээ. Хотынхон урьд нь баяжсан эрэлчдийг харж байсан болохоор энэ нэг үзэгдэл тэдний сэтгэлд найдлага төрүүлэв. Жемийг тэрэгнээс үсрэн буухад мөнөөх хар арьстан зарц залуу үүдэнд зогсож байлаа. Жемин түүний өөдөөс инээмсэглээд,

-Сайн уу? Би эргээд ирлээ гэлээ. Банда мориуг үг дуугүй уяад дэлгүүрт ороход Жемин хойноос нь даган оров. Саломон Ван Дер Мерве худалдан авагчдад үйлчилж байснаа толгойгоо өргөн инээмсэглэхэд нь энэ жижигхэн голланд эр ямар нэг аргаар юм бүхнийг хэдийн олж мэдсэн юм байна гэж Жемин ойлголоо. Алмасын шинэ орд нээж олсон тухай мэдээ бүтэн тив дээгүүр хэрхэн гэрлийн хурдтай тарсны учрыг хэн ч тайлбарлаж үл чадна. Ван Дер Мерве худалдан авагчдад үйлчилж дуусаад дэлгүүрийн цаад руу толгой дохиж,

-Орогтун, мистер Макгрегор гэхэд нь Жемин дагаж орлоо. Ван Дер Мервегийн охин зуухны дэргэд хоол хийнэ.

-Сайн байна уу, Маргерет гэж Жемин мэндлэхэд бүстүүн царай улсхийж буруу харав.

-Чамайг их сонин сайхан мэдээтэй гэж дуулсан хэмээн Ван Дер Мерве мэлийгтэй инээгээд ширээний ард сууж, урдаа байсан тавгийг түлхэн зайлуулж зай гаргав.

-Нээрээ тийм шүү, эрхэм ээ гэж Жемин нүүр бардам хэлээд том савхин уут гаргаж, дотор нь байсан алмасыг гал тогооны ширээн дээр асгахад, Ван Дер Мерве илбэдүүлсэн мэт нэг хэсэг нүд бүлгийн харж байснаа дараа нь нэг нэгээр нь үзсэнээ хамгийн томыг үзэж, дараа нь бүгдийг нийлүүлэн хилэн уутанд хийж, төмөр авдарт дэлд хийгээд цоожлов. Дахин ярьж эхлэхдээ дуу нь үнэхээр бахдан баярласан өнгөтэй байлаа.

-Чи маш сайн ажиллажээ. Макгрегор. Маш сайн байна.

-Баярлалаа, эрхэм ээ. Энэ бол зөвхөн эхлэл. Энд дахиад олон зуун алмас бий. Энэ бүхэн ямар үнэтэйг сэтгэлдээ төсөөлөхөд ч бэрх.

-Тэр хэсэг газартаа бүх дүрэм

журам ёсоор шав тавсан уу?

-Тэгсэн, эрхэм ээ. Хоёр хүний нэр дээр гэж Жемин хэлээд бүртгүүлсэн тухай баримт бичгийг халааснаасаа гаргаж ирэв. Ван Дер Мерве бичиг баримтыг анхааралтай үзээд өөрийн халаасанд хийж

-Чамайг шагнавал зохино. Энд хүлээж бай гээд дэлгүүр рүү орсон үүд рүү явахдаа

-Надтай хамт яв, Маргерет гэжээ. Охин эцгийнхээ хойноос дуулгавартай дагав. "Энэ бүстүүн аймхай муур шиг юм" гэж Жемин бодлоо. Хэдэн минутын дараа Ван Дер Мерве ганцаараа эргэж ирээд,

-За энэ гэж хэлээд трийнвч гарган 50 фунт нарийн тоолж өгөв. Жемин өөдөөс нь гайхан харж,

-Энэ чинь юу юм бэ? Гэсэнд

-Чиний ажлын хөлс, хүү минь гэжээ.

-Ойлгохгүй байна.

-Чи 24 долоо хоног ажилласан байна. Долоо хоногт 2 фунт бодож 48 болж байна. 2 фунт би чамд шагнал болгож байгаа юм... гэхэд нь Жемин тас тас инээж

-Алмасын тэн хагас нь минийх юм чинь би 2 фунтийн шагналаар яах билээ дээ гэв.

-Алмасын тэн хагас ий?

-Тийм ээ, эрхэм ээ. Миний хувь. Бид хамжаа түнш нар шүү дээ гэсэнд Ван Дер Мерве өөдөөс нь нүдээ их болгон ширтэж,

-Түнш ий? Хэн чамд тэгж хэлсэн юм бэ? Гэхэд нь Жемин Ван Дер Мервегийн өөдөөс учрыг ойлгож ядан харж,

-Хэн надад хэлсэн юм бэ гэнээ? Гэрээнд тэгж бичсэн байгаа гэв.

-Чи гэрээг уншсан юм уу?

-Уншаагүй, эрхэм ээ. Африкаанс хэлээр бичсэн байгаа. Та өөрөө бид түнш гэж хэлсэн шүү дээ гэсэнд өвгөн толгой сэгсэрч

-Чи буруу ойлгожээ, Макгрегор. Надад түнш хэрэггүй. Би чамар ажлаа хийлгэх гэж хөлсөлж авсан. Би чамд багаж хэрэгслэл өгч, алмас эрүүлэхээр явуулсан гэхэд нь Жемийн цээж давчдан хилэн бадарч байгаа мэдэрч,

-Та надад юу ч зүгээр өгөөгүй. Би багаж хэрэгслийн үнэд 120 фунт төлсөн гэсэнд өвгөн далаа хавчаад,

-Дэмий маргаж үнэт цагаа үрж байх хүсэл алга. За ингэе. Би чамд дахиад 50 фунт өгөөд хоёул өгөө аваагүй зүйл дуусгая. Энэ бол миний зүгээс өгөөмөр сайхан сэтгэл гэж бодож байна гэхэд нь Жемин тэсгэлгүй хилэгчнэн

-Бидний өгөө аваа дуусаагүй. Бүх алмасын тэн хагас нь минийх. Би

түүнийг авна. Би алмастай хэсгийг хоёр биенийхээ нэр дээр бүртгүүлсэн шүү дээ гэсэнд Ван Дер Мерве жуумалзан

-Тэгвэл чи намайг мэхлэсэн хүн юм байна. Үүний улмаас чамайг баривчилж болно шүү. Энэ мөнгийг аваад эндээс тоннил гээд Жемингийн гарт мөнгө атгуулав.

-Таныг шүүхэд өгнө дөө

-Чамд өмгөөлөгч хөлслөх мөнгө бий юм уу, түүнээс гадна эндхийн бүх өмгөөлөгч нар миний төлөө ажилладаг юм.

"Энэ ер юу болж байна вэ? Хар дарсан зүүд шиг" гэж Жемин бодов. Эзгүй элсэн цөлийг олон сар өдөр үйл тамаа цайж байж туулсан. Үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл шургаж унаглаа ажилласан, энэ бүхнээ нэхэн саналаа. Тийнхүү амна алдахаас наахнуур зүдэрч зүтгэж байж олсон, зүй ёсоор өөрийнх нь хөрөнгийг одоо энэ хүн булааж авах гэж байна. Жемин голланд эрийн нүдийг эгцлэн харж

-Би үүнийг зүгээр өнгөрөөхгүй. Би Клиндрифтээс явахгүй. Таныг намайг яаж муухай залилсныг эндхийн хүн бүхэнд ярина. Би танаас өөрт ноогдох алмасыг авна гэсэнд Ван Дер Мерве харцгыг нь даахгүй нүд дальдран өөр зүг харж,

-Эмчид үзүүлбэл дээр биз дээ, хүү минь. Наранд их шарагдаад тархи толгой чинь гэмтсэн бололтой гэж бөвтнөхөд Жемин ухаасхийн босож өвгөнийг заамдаж аваад

-Чамд харамсах цаг ирнэ гээд өвгөнийг тавьж мөнгийг нь ширээн дээр шидэж орхиод дэлгүүрээс гүйн гарав.

Жемийг "Тэнүүлчин" гуанзанд эргэж очиход тэнд бараг хүн үлдсэнгүй. Эрэлчдийн олонх нь хэдийн Паардспаны зүг явсан байжээ. Хилэн, цөхрөл хоёр Жемийн цэжийг урж байлаа. "Хүн үнэмшмээргүй юм. Тун саяхан Крез шиг баян байснаа одоо дахиад л адгийн муу гуйлгачин болчихлоо. Муу хулгайч Ван Дер Мервег цэрлүүлнэ. Харин яаж?" гэж Жемин бодов. Ван Дер Мервегийн хэлдэг үнэн. Жемид өмгөөлөгч хөлслөн авах мөнгө байхгүй. Энэ газар Жемид таних хүн байхгүй. Ван Дер Мерве бол бүхэнд хүндтэй голланд хүн. Жемид байгаа ганц зэвсэг гэвэл үнэн үг. Өөрийгөө Ван Дер Мервегийн хэрхэн мэхлэснийг Өмнөд Африкийн бүх хүн ардад ярина. Баарын хүн мэндлэн угтаж,

-Тавтай морино уу, Мистер Макгрегор. Бүх зардлыг манайх даана. Юу авах вэ?

-Виски.

Смитийн хийж өгсөн 2 хувь вискийг Жемин нэгмөсөн хөнтрөв. Архи ууж сураагүй болхоор галт шингэн хоолойг нь зурлаа.

-Дахиад виски.

-Одоохон. Виски хэнийг ч унагаж чадна гэж би хэлдэг юм даа.

Хоёрдахь хувь виски арай амархан оров. Баарны хүн нэгэн эрэлчинд хандан Ван Дер Мервегээ тусламж гүй хэмээн хэлж байсныг Жемин санаад,

-Ван Дер Мерве өвгөнийг луйварчин гэж та мэдэх үү? Миний алмасыг мэхлээд авчихсан гэсэнд

-Яасан аймаар юм бэ. Хүн үнэмшмээргүй юм байна гэж Смит өрөвдсөн байдалтай өгүүлэв.

-Түүнийг зүгээр өнгөрөөхгүй. Алмасын тэн хагас минийх. Ван Дер Мерве муу хулгай. Үүнийг би хүн бүхэнд ярина гэж Жемин хэлэхдээ хэл нь ороолдон байв.

-Мэдээтэй л байгаарай. Ван Дер Мерве энэ хотод их эрх мэдэлтэй хүн шүү. Чи түүнтэй нэгийгээ үзье гэж байгаа бол чамд тусламж хэрэгтэй.

Ингэхэд миний мэдэх нэгэн хүн бий. Бас л Ван Дер Мервег үзэн яддаг юм гэж Смит яриад ийш тийшээ хараад дуугаа намстан

-Гудамжны үзүүрт нэг муу шин бий. Би бүгдийг ярьж тохирьё. Өнөө орой тэнд 10 цагт очоорой гэхэд нь

-Баярлалаа. Таны ачийг мартахгүй гэж Жемин харуулав.

-Орой 10 -г, хуучин муу пинд

Пин гэдэг нь биржээр төмрөөр яаруу хийсэн нэг муу байшин шуу юм байв. Тэр пин хотын захын гудамжны үзүүрт байлаа. Жемин оройн 10 цагт тэнд очив. Харанхуй болжээ. Пингийн хажууд хүн харагдахгүй болхоор нь дотогшоо орлоо.

-Хүн байна уу?

Хариу байдаггүй. Жемин урагшаа яаралгүй алхав. Харанхуйд адууны дүрс бүдэгхэн харагдаж, ард нь чимээ сондсоход Жемин эргэж харах гэтэл толгой дээрээс нь чанга цохиход хөсөр унав. Нэг их тэнхээтэй хүн түүнийг толгой түрүүгүй балбаж эхэллээ. Зодож занчих нь хэзээ ч дуусахгүй янзтай. Өвдөхийг тэсэх тэнхээ тасарч байтал ухаан алдав...

Дээрээс нь хувингаар ус асгалаа. Нүдээ нээхэд Ван Дер Мервегийн негр зарц Банда харагдах шиг болов. Түүнийг дахин балбаж эхэллээ. Хавирга нь нугингахыг Жемин мэдэв. Хол рүү нь нэг хүнд юмаар яс нь шажигнахыг сонслоо. Дахиад л ухаан алдлаа.

Хамаг бие нь халуу оргиж байлаа. Хэн нэгэн хүн нүүр амгыг нь төмрийн зүлгүүрээр маажиж байх

шиг санагдан гараа өргөн саатуулах гэтэл гар нь даагдсангүй. Нүдээ нээх гэтэл зовхи нь бүлцийж хавдаад юу ч харагдсангүй. Хамаг биений эд эс бүхэн тэсэхүйеэ бэрх өвдөхийг мэдрэн хаана байгаагаа санах гэж оролдож үзэв. Жаахан хөдлөх гэтэл нүүрийг нь төмөр зүлгүүрээр дахин маажих шиг боллоо. Гарын дор эргэн тойрон элс байгаа нь мэдэгдэв.

Шархалсан нүүрээрээ элсэн дээр хэвтэж байжээ. Өлөн гиншиж өвдөг дээрээ өндийхийг оролдож, нүдээ нээх гэтэл хий бүрэлзэхээ өөр юм харгадсангүй. Жемин эзгүй хээр цөлд чармай нүцгэн хэвтэж байлаа. Өглөө болж, шарх сорви болсон биений нар хайр гамгүй төөнөв. Тэд Жемийг энд үхэг гээд орхисон байж. Саломон Ван Дер Мерве, баарны эзэн Смит хоёрын хийсэн ажил. Жемин голланд өвгөнийг занаж зүхсэн. Хариуд нь ингэж тамлан зовоохоор шийджээ.

"Тайгүй ээ, сайхан мэдээтэй. Чи үүнийхээ горийг амсана. Би чамас заавал ошөөгөө авна. Тэр хоёр хоёулаа үүнийхээ төлөөнийг үзнэ" гэж Жемин бодов. Хэдийгээр хавирга нь хугарч, амьсгал авахад хэцүү байсан боловч зүүн ядах сэтгэл нь хүч өгнө...

Хугарсан хавирга уушгийг цоо хатгахаас болгоомжлох хэрэгтэй юм. Жемин босох гэж оролдоод тэр дороо ойчлоо. Баруун хөл нь бас хугарчээ. Ингээд хаашаа ч явж чадахгүй болжээ.

Мөлхөж л чадна...

Жемин хаана байгаагаа мэдэхгүй байв. Тэд нар түүнийг гол замаас хол, цөөвөр чоно, дэлт бүргэдээс өөр хэн ч олохын аргагүй тийм газар хаасан бололтой. Цөл бол асар том оршуулгын газар юм. Жемин өөрөө сэг иддэг амьтдын цав цагаан болтол мөлжсөн хүний ястай дайралдаж байсан нь нэг биш. Түүнийг ийнхүү бодож завдаагүй байтал дээгүүр нь дэлт бүргэдийн далавч сүрчигнэх, сийгүүлэн дугарах чимээ сондов. Тэрээр махчин амьтдын барааг харж чадаагүй ч үнэрийг мэдээд айдас төрөв.

Жемин урагш мөлхлөө.

Өвдөхийн зовлонг элдэс нь тэр ээ...

Өчүүхэн төдий хөдлөх бүрд тэсэхүйеэ бэрх шахиан зовно. Нэг талаараа мөлхөхөд хугарсан хөл нь янгианаа. Нөгөө талаараа мөлхөх гэхэд хугарсан хавирга нь хоорондоо хавиралдана. Хөдлөхгүй хэвтээд байх нь тамын зовлонг, хөдлөхөөр амь тавих шахна. Гэсэн ч Жемин мөлхсөөр байлаа.

Үргэлжлэл дараагийн дугаарт...

ТЭНГИС

КИНО ТЕАТР

Элдэв-СЧИР ФИЛМС
LINE ENTERTAINMENT
WONDERWORKS LLC

ANTONIO BANDERAS BEN KINGSLEY

9 / 0 2 - 0 4 ҮЗВЭРИЙН ХУВААРЬ

<p>10:30 12:25 14:05 15:45 17:25 18:35 20:15 21:55 VIP 16:50 22:50</p>	<p>10:45 12:40 14:20 16:00</p>	<p>10:35 12:25 14:15 16:05 17:55 19:45 21:40 23:30</p>	<p>20:35</p>
<p>Vip 16:50 22:50</p>	<p>17:40 19:35 21:25 VIP 12:55</p>	<p>19:10 21:05 23:00 VIP 11:00 14:50 18:30</p>	<p>10:40 14:35 18:35</p>
<p>10:30 12:05 14:15 16:25 23:30 VIP 20:30</p>	<p>12:40 16:40</p>	<p>23:15</p>	<p>23:15</p>

ШИЛДЭГ КОНТЕНТИЙГ ТҮГЭЭГЧ ҮНДЭСНИЙ КОМПАНИ

ТӨСӨВӨЛЛӨВС ИЛҮҮГ ТЭНГИСЭЭС...